

Чингис хааны онгоныг судлах асуудалд

**МОНГОЛ ХААДЫН ОРШУУЛГЫН ТУХАЙ ДУНДАД ЭРТНИЙ
ГАР ЗУРГИЙН ЗАРИМ МЭДЭЭ**
(Чингис хааны алтан хайрцагны (авсны) тухай дүрслэн үлдээсэн нь)

Г.БАДАМСАМБУУ

МҮОНТВ, “Гараг” продакшнс
e-mail: garag_world@yahoo.com

Түлхүүр үгс: Монгол оршуулга, Чингис хаан, Перс иллюстраци (үзүүлэн зураг), Бурхан халдун, Илхаадын миниатюр (Номын чимэглэл зураг), Рашид-Ад-Дин

ТОВЧ АГУУЛГА: Дундад эртний Монголын Эзэнт гүрний сэдэв бүхий Перс номын чимэглэл (үзүүлэн) зургуудад түүхэн нууцлаг үйл явдлын зарим мэдээллийг үлдээсний нэг нь Чингис хааны оршуулгын тухай юм. Монгол язгууртны оршуулга болон Их хааныг онголсон сэдвээр Рашид-Ад-Диний “Судрын чуулган”-тай шууд болон дам холбогдох зарим гар зургуудыг энд эрэн цуглуулж, зохих ажиглалт хийлээ. Ажиглалт хийсэн эртний гар зургуудын олонх нь Чингис хааны оршуулгатай холбоотой нэрээр зарим судалгааны бичвэрүүдэд хавсран хэвлэгдсэн ба өөр хоорондоо ялгаатай зургууд хирнээ дундад эртний монгол язгууртны оршуулгын зан үйлийг ижил төстэй мэдээллээр тод тусган харуулснаараа нийтлэг шинжтэй байна. Монгол удирдагч болон язгууртны оршуулгыг (авс, эд өлөг, ёслол бэлгэдэл, зан үйл гэх мэт) нүдэнд харагдах (визуальный ба visual) аргаар дүрсэлсэн Перс номын чимэглэл зургууд нь эртний тайлагдаагүй нууцын (хаадын оршуулга) талаар бодтой баримт сэжим болох боломжтойг ажиглалт баталж байна. Судалгаанаас үзэхэд, гар зургийн өвүүдэд дүрсэлж үлдээсэн угсаатны зүй, зан үйлийн хэв шинж нь Дундад эртний монголчуудын оршуулгын тухай өгүүлсэн түүхэн сурвалжууд, бичгийн эхийн баримтуудыг даруй нотолж, шинэ мэдээгээр баяжуулан баталгаажуулж байна. Шинээр анхаарал татаж буй Чингис хаан ба монгол хаадын онгон судлалаас гадна монгол (язгууртны) оршуулга, эртний зан үйлийг шинжлэн танихад энэ ажиглалт-мэдээлэл зохих ач холбогдлоо өгөх юм.

Перс судрын зарим зургуудад ажиглалт хийж уг өгүүллийг бичихдээ тэдгээрийн голлох шинж чанарт үндэслэж үзүүлэн таниулах зураг (иллюстраци) нэр томъёог түлхүү ашиглахын зэрэгцээ монгол болон зарим судалгаанд түгээмэл хэрэглэх болсон номын чимэглэл зураг (миниатюр ба бичил чимэглэл) нэрийг ч мөн ашиглав.

Дундад эртний Монголын Эзэнт гүрний тухай Перс номын үзүүлэн (чимэглэл) зургууд нь ажиглалт, шинжилгээ хийж судлах зайлшгүй шаардлагатай, олон эш баримтыг өөртөө тээж байдаг түүхэн онцгой шинж чанар бүхий өв дурсгал, бодтой эх сурвалж билээ. Түүхэн бичлэгийг баяжуулах онцгой арга хэлбэрийн үүрэгтэй бүтээгдсэн номын (үзүүлэн таниулах(иллюстраци) зорилготой эдгээр зургуудыг олон судалгаанд “чимэглэл зураг ба миниатюр” гэж нэрлэж ирсэн байдаг. Зохиогч) зургууд нь өөрийн оршин байгаа сурвалж бичигтэйгээ хам сэдвийн уялдаатай байж, түүхэн үйл явдлын бичлэгийг дүрслэл амьдчиллаар нэмж батлах төдийгүй дангаараа бие даасан нотлох хэрэглэгдэхүүн болж чадах үнэ цэнийг ч агуулдаг. Ер нь тухайн цаг үеэс нүдэнд харагдах баримтат гол өв болох гар зургууд нь монголчуудын тухай (мөнхүү цаг үед өрнө, дорнод зурагдсан) угсаатны зүй, түүхэн үйл явдал, зан үйлийг тусган хадгалсан төдийгүй тэр үеийн Еврази дахь улс төрийн бодлого, соёлын солилцоо, хөгжлийн хувирал өөрчлөлтийн ул мөрийг хадгалсан байдаг. Түүгээр ч барахгүй түүхэн нууцлаг үйл явдлын зарим сэжим мэдээллийг гар зурагт үлдээсэн нь цөөнгүй тааралдана. Эдгээрийн дотор Чингис хаан ба монгол хаадын оршуулгын тухай дүрслэн үлдээсэн сэдэв бий. Чингис хааны бунхан (оршуулга) бол дэлхийн тайлагдаагүй түүхэн нууцын нэг билээ. Бичмэл сурвалжуудад энэ талаар тодорхой тусгаагүй (нууцлагдсан) боловч Монгол хаадын (Чингис хааны үр ач нар) удирдлага дор зөвлөл байгуулж, Эзэнт гүрний түүх ба дэлхийн түүхийг бичих даалгаврыг Перст гүйцэтгэж байсан олон үндэстний эрдэмтэн, зураачдын “ажил”-д уг сонирхолтой сэдвийг тусган үлдээсэн байж болохоор байдаг.

Дундад эртний Монголын эзэнт гүрний тухай гар бичмэлүүд (эх сурвалжууд) нь түүхэн бичлэгийг дэлхий ертөнцийн хэмжээний өргөн царамтай болгосон анхны эх сурвалжууд болдоггоороо гайхалтай билээ. Энэхүү үнэ цэнэтэй сурвалжуудыг Монголын нууц товчоо (1240, Монгол), Плано де Карпини (Ystoria Mongalorum quos nos Tartaros appellamus, 1248, Франц), Вилгельм Рубрук (Hystoria Tartarorum, 1256, Франц), Ата Мелик Жувеини (Ta-rikh-i-Jahan-Gusha, 1260, Перс), Марко Поло (Le divisament dou Monde, 1295, Итали), Рашид-Эд-Дин (Jami' al-Tavarikh, 1310-аад, Перс) зэрэг XIII-XIV зууны сурвалжууд тэргүүлдэг. Эдгээр судрын дотор номын эртний үйл явдлыг дүрсэлсэн гар зургуудыг элбэг үлдээсэн байдлаараа Рашид-Ад-Диний “Судрын чуулган” (Jami' al-Tavarikh, 1310-аад, Перс) онцгой үнэ цэнэтэй юм.

Рашид-Ад-Диний “Судрын чуулган”-ы перс эх, мөн түүний зарим хуулбарын үзүүлэн зургуудад (чимэглэл, миниатюр зураг ч гэдэг) Чингис хаан болон Монгол хаадын оршуулгыг сэргээж дүрслэн үлдээсэн бололтой байна. Мөн эндээс монгол угсаатны эртний оршуулгын зан үйлийн талаар олон зүйлийг танин мэдэж, нотолж болно. Дэлхийг байлдан дагуулагчийн түүхийг перс хэлээр бичүүлэхдээ, Монгол удирдагчдийн даалгавраар дэлхийн өнцөг булан бүрээс олон зураачдыг (Хятад, Монгол, Европ, Перс, Араб) авчирч оролцуулсан ба түүхэн бичлэгт монгол зөвлөхүүд бас оролцжээ гэдэг. Тиймээс түүхэн гар зургуудад дүрслэлийн олон арга барил туссан байдгаас гадна тэдгээр гар бичмэл судрыг олшруулж хуулбарлахдаа ч түүхэн үйл явдлын гар зургуудыг мөн тэр хэвээр хуулбарлан зурдаг байжээ.

“Судрын чуулган”-ы үзүүлэн (чимэглэл) зургууд нь бүтээгдэж байсан цаг үеэсээ урагш 1500 шахам жилийн тэртээг хүртэл өргөн цар хүрээтэй сэдвийг хамарч, өнө эртний түүхийг сэргээн дүрслэх гэж оролдсоноороо гайхалтай туурвил бөгөөд Чингис хаан болон түүний өвөг дээдсийн үйл явдалтай холбоо бүхий нилээд хэдэн зургийг агуулсан байдаг.

* * * *

Чингис хааны онгоныг эрэн шинжлэх үндсэн асуудал нь уг сэдэвтэйгээ дам холбоо бүхий дагалдах жижиг сажиг зүйлсийг ч хянуур нотлох, таамаглах, төсөөлөх, учир холбоог нягтлан судлахад хүргэж байгаа билээ. Жишээлбэл, Их хааны шарилыг Бурхан Халдунд оршоосон нь үнэн бол түүнийг хэрхэн, ямар дүр төрхтэйгээр, аль чиглэлээр олон зуун бээр газрыг туулан тээж ирсэн бэ, хэрхэн, ямар аргаар дулаан улиралд хадгалж, хамгаалж явсан бэ, эцэст нь шарилыг бунхалсан уу, энгийн даруу оршуулсан уу, яригдаж бичигдэж ирсэн домгууд, мэдээллүүдийн аль нь үнэнд дөхөх вэ гэх мэт... Мөн мөнх бусын тухай Их хааны өөрийнх нь үзэл, ойлголт ямар байж болох, түүний оршуулгад бусад соёл, иргэний болон шадар зөвлөхүүдийн нөлөө байж болох эсэх, тэнгэрт халих үеийн холбогдох хэрэг явдлууд, гэрээслэл, өв залгамж, түүний эзэмшил дэх олон иргэний оршуулгын зан үйлийн ул мөр гэх мэт, тэр ч бүү хэл Чингис хааны онгоны байгууламж ямар бүтэц, хэлбэртэй байж болох, хэдий хэр баялаг-эд өлөг агуулсан гэх мэт адал сониуч асуултууд-оньсогууд ар араасаа хөвөрч байна. Чингис хааны оршуулгыг маш нууц оньсого хэмээн тэмдэглэж ирснээс хойш таамаглан бичиж, сурвалжилсан олон эх сурвалжуудад эдгээр асуултуудыг тавьсан нь үе үе тааралдана. Чухамдаа Чингис хаан-эцгийнхээ хойдын тайлга, хойлго, онголох хэргийг гардан удирдсан гэх отгон хүү Тулуй хаан л ертөнцийн энэ нууцыг сайтар мэдэж үйлдсэн биз ээ. Тиймээс Их Онгоныг (бунханыг!) судлахад Тулуй хааны хожмын хэрэг явдлуудыг анхааран үзэх шаардлага гарах мэт. Ренэ Груссе өгүүлэхдээ “Чингис хааны өөд болсны дараа монгол заншлын дагуу голомт сахигч Тулуй Их хааныг шинээр өргөмжлөх хүртэл (1227-1229 он) түр хаанчилж байв. Ордос дахь хан эцгийн чачир тугдан, өрхийн тэргүүлэгчийн сэнтий болон 1227 онд монголын цэргийн бие бүрэлдэхүүнд багтаж явсан (түүний дотор Чингис хааны ойр дотны цэргийн мэдэлтнүүд, хишигтэн, хэвтүүл, торгууд цэргүүд. Зохиогч) 129 мянган хүн, түүний дээр 101 000 хүн Тулуйн мэдэлд байв” (Груссе, 2004) гэсэн байна. Тулуйн хаан эрх мэдэл, хүн хүчээ үлэмж бунхан бүтээхэд дайчлан зориулаагүй, энгийн нууц оршуулгыг л ахалсан байж болно гэдгийг батлах ноттой түүхэн мэдлэг одоохондоо бидэнд алга. Түүх судалгаанд “Шарилыг (Чингис хааны. Зохиогч) маш их сүр бараа бүхий гашиудлын цуваагаар... Бурхан Халдун ууланд авчирч нууц газар оршуулсан... Өгэдэй хаан 1229 онд том өргөл тахилга үйлдэж...” (Саундерс, 1992: 72) гэсэн нь нилээд эртнээс олонх судлаачдын үндсэндээ хүлээн зөвшөөрч ирсэн гол үзэл санаа юм.

Ямар ч атугай Чингис хааны шарилыг Бурхан Халдун буюу Их хааны өөрийнх шүтээний оройд үлэмж бунхан хэлбэрээр оршуулсан гэх зарим эрдэмтэн судлаачдын (Батсайхан, Даваа, Бор, 2009: 13-26) шинэ санал эдүгээ өдрүүдийн сонирхол татсан мэдээ болж байна. Ийм цаг үед, доор өгүүлж буй монгол (хаадын)

оршуулгын тухай эл өгүүллийн санаа нь дээрх чухал сэдэвтэй холбогдож, зарим шинэ мэдээллийг өгч байна.

Дундад эртний гар зургийн зарим бүтээлд Чингис эзний авс (алтан хайрцаг)-ны тухай мэдээлэл үлдэн хоцорсон нь сонирхолтой. Их хааны оршуулга ба авс (алтан хайрцаг) нь түүнийг оршуулахдаа бунхалсан, эсхүл жирийн эгэл энгийн булшилсан (мэдээж нууцалсан!), байгальд шингээсэн, эсхүл чандарласан зэргийн аль нь байж болохоос шалтгаалан өөр өөрөөр төсөөлөгдсөн байдаг.

Ер нь судлаачдын анхаарал татах бас нэг зүйл бол Их хааны жинхэнэ шарилыг тээсэн үү, чандар мэт зүйлсийг, эсхүл онголох эд өлгийг тээж төрсөн нутагт нь авчирсан уу гэдэг асуулт юм. Өнөө болтол олонх судлаачид шарил буюу цогцосыг өлгий нутагт (Монголд) нь авчирсан гэх үзэлтэй байдагийг дээр дурдсан. Гэвч түүхэн сурвалжуудын эх хэлнээ хэрхэн өгүүлсэнийг анхаарахын зэрэгцээ тэдгээрийн монгол орчуулга, хөрвүүлгүүдэд “... цогцос” (Ренэ Груссе, 2004: 51), “шарил” (Марко Поло, 1987: 69), “... онгон” (Амар, 1989: 162), гэгээн...монгон...чандарын гэгээн, үнэн чандар (Инжинаш, 2005: 375-379), “гэгээн ... чандар” (Рашид-Ад Дин, 2002), “алтан хүүр, ... мөнх хүүр (хүүр), ... үнэн хүүр ...” (Лу “Алтан товч”, 1990: 144, 146) гэх зэргээр тааралдаж ирснийг нарийвчлан нягтлууштай. Ийн судлан мөшгөж гэмээнэ, эх сурвалжуудад Чингис хааны онгоны зарим нэг дүр төрхийн талаар магадтай сэжүүр тусаж үлдсэн эсэхэд хариулт олж болох юм.

Юуны өмнө Чингис хааны “үнэн хүүр”-ээс юу ч, хэзээ ч олдохгүй байж болохоор оршуулгын зарим мэдээ бас байдаг. Энэ нь Их хааныг Ононгийн савд онголсны дараа мөрөн голын урсгалыг өөрчилж, бунхан дээгүүр нь (Эртний Месопотамийн хаан Гилгамишийн адилаар) урсгасан гэдэг домог бий. Мөн Рашид-Ад-Диний “Судрын чуулган”-д “...Чингис хааны дөрвөн хатан нь түүний онгоныг дөрөв хэсэглэж чандар болгожээ” гэсэн байна. Эдгээрээс үзвэл, Хааны цогцсыг илтэд ул мөргүй болгон хувиргасан байж болох мэт (гэхдээ уулын ар, голын гольдролд Монгол хүн хэзээ ч оршуулга үйлдэх учиргүйг анхаарах!). Монгол сурвалж Саган цэцэний “Эрдэнийн товч”-д (1662) өгүүлэхдээ Чингис хааны авсыг эх нутагт нь ирээд онгойлгоход хоосон байсан тухай тэмдэглэжээ.

Гэтэл хуучин домгуудын нэгэнд “Чингисийн ... шарилын тэргүүн тал нь ургах нарны зүг харсан байх байдалд гаргахад (олж гаргавал. Зохиогч) ямар ч аюулгүй байх бөгөөд гарах цаг нь болсон... “Шарилыг удаан хугацааны турш нар жаргах зүгээс... ургах зүг рүү эргэхээр... байрлуулсан...” (Эзэн богд ..., 1992: 57) гэжээ. Тумбулл “Монгол дайчин” (Tumbull, 2003: 24) бүтээлд дурдахдаа Их хааны онгоныг нас барснаас нь 30 жилийн дараа дахин нээгдсэн гэжээ. Өөр нэг мэдээ нь Жамбадорж “Болор толь”(1836 оны үе)-д Их хааны цогцосыг тохой хиртэй жижигхэн болтол нь занданиуулж, дараа нь алтан хуурцагт (хайрцаг, авс. Зохиогч) хийж онголсон гэдэг. Алтан ургийн хожмын бичээч Инжинаш бээр эртний олон судрыг харьцуулан туурвисан “Хөх судар”-т (Инжинаш, 2005: 378) “... хааны алтан савын гадуур давхар мөнгөн гэр, гадуур төмөр авдар гурван давхар байгуулж, бас энэ мэт нэгэн адил дөрвөн сав, дөрвөн гэрийг бэлтгээд” дөрвөн тийш төөрүүлэх зорилготой оршуулахаар тээсэн тухай өгүүлсэн ба судалгаагаар хамгийн үнэн магадтай байж болох чиглэл буюу Бурхан Халдуны оршуулгыг (Зохиогч) “Туравдугаар чандрыг Алтай ханы ар, Хант ханы өрх дагуулан хад модны шилэнд мөнхүү мянган газрын урт ухааж оршуулан бас тэгишилж чулуун гэр босгож гэгээн болгов. Дөрөвдүгээр гэгээнийг

Бурхан Галдуна-гийн өвөр Онон мөрний талд мөнхүү мянган газрын ордон болгож оршуулан, бас тэгшилж модон гэр босгож гэгээний тахилга болгов. Эдгээрийг оршуулахуйд урьдаар бөс хүрээ шороон унуулыг эрж (малтаж, хөр.) ... сая оршуулан чандрыг тэгшилсэн хойно сая цэргийг тавин оруулж их шороог тэгшилмүй” гэжээ. Энэ бүхнээс үзэхэд, оршуулгын үйл явдлын зарим мэдээ цөөн боловч бичмэл сурвалжуудад тэмдэглэгдэж, домог зэргээр мэдээлэгдэн үлджээ. Цохон хэлэхэд, Их хааны оршуулгын дүр төрхийн талаар бүх үеийн түүхэн сурвалжуудаас хамгийн сониноор, сайтар дүрсэлсэн бичмэл сурвалж нь “Хөх судар” (XIX зууны төгсгөл) болох юм. Гэтэл түүх судлаачид (мөн Их хааны онгоныг хайгчид) “Хөх судар”-ыг Чингис хаанаас хэт хожуу үеийн (үнэ цэнэ багатай), уранзохиол давамгайлсан бүтээл хэмээн ойлгож /ташаарч/ ирсэн тул энэ хүндэт өвийг өдгөө болтол түүхэн судалгаанд чухалчлан анзаарахгүй явж иржээ. Үнэн хэрэгтээ бол дорно зүгийн түүхэн бичлэгийн сонгодог аргаар, нарийн судалгаа, эх сурвалжтай, үе дамжин бичигдсэн нэн чухал бүтээл бол “Хөх судар” билээ. Алтан ургийн хойч, эрдэмт хүн Инжинаш бээр Чингис хааны онгоны талаарх өөрт байгаа нууц мэдээллүүдийг харьцангуй нээлттэй бичиж үлдээх цаг үе мөн эсэхийг мэдэж байсан нь эргэлзээгүй юм. Чингис хааны онгоны талаар өнөө цагийн зарим судлаачдын баг урьдчилсан таамаглалаа батлах эх сурвалжийн судалгааны явцад Инжинаш авхай мэдээллийг олж анзаарсан нь судалгаанд үлэмж тус болж байна.

Чингис хааны оршуулга, тэр дундаа хааны авс (алтан хайрцаг ба Эзний хуурцаг), мөн монгол язгууртаны оршуулгын талаар дүрсэлсэн дундад эртний уламжит зарим гар зургийн өвүүдэд ажиглалт хийснээ дор толилуулав.

Чингис хааны оршуулга (Зураг 1)


Чингис хааны оршуулга (Funeral of Genghis khan). Хэсэг. Рашид-Ад-Дин “Судрын чуулган”. XIV зууны эхэн. Персийн Supple pers. 1113. хуудас 117. Францын үндэсний номын сан. Парис. Мөн “Чингис хааны авс”(Coffin of Genghis khaan) нэртэйгээр. Ташкентийн үндэсний музей. Узбекистан.

Чингис хааны оршуулга ба хааны алтан хайрцгийг дүрсэлсэн Рашид-Ад-Диний “Судрын чуулган”-аас (XIV зууны эхэн) сурвалжтай нэгэн Перс гар зургийн хэсэг (Зураг 1) ховор боловч тархсан байдаг. Энэ зураг бол Хааны оршуулгын тухай бусад гар зургаас харьцангуй үнэ цэнэтэй, нэн сонирхолтой түүхэн мэдээлэл агуулсан нь байж болох юм гэж үзэж байна. Ил хаадын (Монгол хаад) дэргэд байж, тэдний түүхийг удирдан бичүүлж байсан Рашид-Ад-Дин нь хааны алтан ургийнхнаас чухал түүхэн мэдээлэл авч байсан төдийгүй Юань (Монголын эзэнт гүрний төв) улсаас томилогдсон Болод чинсан нарын монгол зөвлөхүүдийн зааврыг тусгасан нь тодорхой. Тиймээс хааны оршуулгын тухай хамгийн ойр чухал мэдээлэл, үйл явдалд үндэслэн уг гар зураг зурагдсан байх боломжтой. Энэ чимэглэл зураг нь хоёр өөр сурвалжид Чингис хааны оршуулга “Funeral of Genghis khan” (Roux, 2003: 32) ба Чингисийн авс “Coffin of Genghis khan” (http://afe.easia.columbia.edu/mongols/figures/figu_ogo.htm) нэртэйгээр хэвлэгджээ. Зургийн нэг эх нь Узбек улсын нийслэл Ташкентийн үндэсний музейд хадгалагдаж байгаа тухай АНУ-ын Колумбын Их сургуулийн сайтад тэмдэглэгдсэн бол, мөн яг

үүнтэй ижил зураг Францын үндэсний номын сангийн цуглуулгад (Парис)-д хадгалагдаж байгааг судлаач Жан Поль Ру номондоо (Roux, 2002) хавсаргажээ. Энэ сонирхолтой түүхэн зургийн бүрэн бүтэн эх нь ямар болох, мөн аль нь жинхэнэ эх болох (перс, араб аль хэлээр), эсвэл хуулбар эх эсэхийг мэдээлсэн зүйл үгүй. Рашид-Ад-Диний “Судрын чуулган”-ы хамгийн эртний араб эх хуудсууд хадгалагдаж байгаа гэгдэх Насир Д. Халилийн “Исламын урлагийн цуглуулга” (59 хуудас, Их Британи, Лондон), Эдинбургийн Их сургуулийн номын сан (151 хуудас, Их Британи, Шотланд)-д уг чимэг зураг байхгүй байгаагаас үзвэл, магадгүй дэлхий дээр үлдэж хоцорсон хоёр перс эх (Турк, Истанбул, Топкап ордон) зэрэгт уг ховор чимэглэл (үзүүлэн) зургийн унаган эх ба мэдээлэл хадгалагдаж байгаасай гэж найдахаас өөр аргагүй. Мөн хэсэг бусгаар тарж үлдсэн араб судрын “тасархайнууд” болон хуулбарлан хувилсан эхийн хэсгүүд болох (дээр дурдсанаас гадна) өдгөө Их Британи (Лондон), Герман (Берлин), Энэтхэг (Рампур) улсуудад хадгалагдаж байгаа эхүүдэд ч уг зураг үлдсэн байхыг үгүйсгэх аргагүй.

Юуны өмнө уг зураг нь угсаатны зүй, түүхэн үйл явдал, дүрслэх урлагийн чухал дурсгалын нэг болно. Ер нь Монголын эзэнт гүрний тухай түүхэн судруудад тайлбар үзүүлэнгийн агуулга, хэлбэрээр бүтээгдсэн Перс гар зургууд нь алдаа оноотой боловч эртний түүхэн хэрэг явдлыг нүдэнд харагдаж, гарт баригдах арга барилаар (зургаар!) тухайн үеийнхээ хамгийн итгэмжит сурвалжаас үлдээснээрээ давтагдашгүй үнэ цэнэтэй өв байж иржээ. Эх зураг (Зураг 1)-ийн үндсэн дэвсгэр өнгө нь Этүгэн эх газрын бор шаргалаар голлож, том ногоон навч улаавтар цэцэгт ургамал элбэг ургаснаар дүрсэлжээ. Уул толгодын энгэр дэвсэг гэмээр газарт, урт шилмүүст, өтгөн навч бүхий ганц модны дор Их хааны алтан товруу хээгээр (алтлаг өнгөт хээ чимгээр) урласан (тансаг), дөрвөлжин (жигжиг дөрвөн хөлтэй), хүрэн өнгөт авсыг байрлуулсан нь зургийн үйл явдалын төв болж байна. Эртний заншлаар авсны эргэн тойронд хүмүүс бүгд толгой нүцгэн, эмэгтэйчүүд нь үсээ задлан унжуулж гашуудна. Гашуудаж байгаа хүмүүс эрэгтэй, эмэгтэйгээр хоёр талд хуваагдан шарилын зүг (шарил авснаас үл үзэгдэнэ) хандан зогсоцгоожээ. Эмэгтэйчүүд, эрчүүдийн царай, хувцасыг илт ялгагдахаар дүрслээгүй ч эрчүүдийг сахлынх нь байдлаар, гашуудан зогсож буй байршлаар нь таньж болно. Зураг дээр 14 хүнийг (9 эрэгтэй, 5 эмэгтэй) ташуу захтай хар, хөх, цэнхэр өнгөт дээлтэйгээр дүрсэлсэн байна. Эдгээр хүмүүс нь бичмэл эх сурвалжийн мэдээгээр бол тэнгэрт хальсан хааны оршуулгад оролцсон алтан ургийн цөөхөн чухал хүмүүс гэлтэй. Зурагт эрэгтэйчүүдийн зогсох талыг голлох үйл явдлын хэлбэрээр дүрсэлсэн ба эрчүүд толгой гудайлган, энгэрээ ярах, өвчүүндээ гараа авах зэрэгээр гашуудан байна. Хар хувцаст нэгэн эр Хааны шарил руу тонгойж, авсанд баруун гараа хийж, ямар нэг зүйлийг засаж янзлан (энэ нь эртний заншлаар авсанд эд зүйлс дагуулан хийж) байгаа мэт харагдана. Энэ нь авсыг таглаагүй (битүүлээгүй) байгааг илтгэнэ. Үйлдэл дүрсэлсэн энэхэн хэсгийг Хааны (шарилын) тэргүүн хандсан зүг гэж үзэж болох мэт. Хааны өлмий чигт эмэгтэйчүүд гашуудан зогсоцгоох бөгөөд тэдний байдал аягаас үзвэл сэтгэл хөдлөл нь эрчүүдээс илүү тод дүрслэгджээ. Авсны ойр

зогсох эмэгтэй үсээ үгтээн (толгойгоо барин) гашуудаж, нэг нь тэнгэрт залбиран (гараа алдлан дээш өргөж) хандаж, бусад нь нулимс арчих мэтээр зурагджээ.



Зураг 1. Чингис хааны оршуулга

Зураг дээр эрэгтэй, эмэгтэйчүүдийн зогсох байршил, дүрслэлийн төв (авсны хэсэг) хэсгийг тодруун тусгасан зэрэг нь төрийн ёслолыг үйлдэхэд баримталдаг (перс иллюстрациудад зурж үлдээсэн) дундад эртний монголын ёс журамтай адил байна. Зургийн нэгэн гол үйл явдал бол тансаг авсны наадтай хоёр эр өөд өөдөөсөө сөхрөн суусан байх бөгөөд тэдний дунд улаан цэцэгт бутлаг ургамал тэгш хэмтэй байдлаар тод дүрслэгдэж (зан үйлд хэрэглэдэг үнэрт ургамал, мөн эртний нүүдэлчин Түрэгийн оршуулгад хэрэглэдэг байсан лийрийн мод (тэнгэрийн мод) (Мырзатай, Каржаубай, 2006) байж мэдэх), түүний доодтой ямар нэгэн багаж зэмсэг (эсвэл эд өлөг) мэт зүйл газар дээр үзэгдэнэ. Сөхрөн суусан хоёр эр уг зэмсгээр (эд

өлөгөөр) ямар нэг зан үйл хийж буй бололтой. Хааныг оршуулах газрыг хөндөж байгаа юм уу, эсхүл авсанд хийх эд зүйлсийг бэлдэж, үгүй бол арц хүжисийн сав мэт зүйлийг энд харуулжээ гэмээр. Зураг нь энэ мэт монгол оршуулгын зан үйлийн олон мэдээллийг агуулсан байна. Алтан ургийнхны захиалгаар бүтээсэн түүхийн эрхэмсэг нандин сударт (“Судрын чуулган”-д) хичээл зүтгэл шаардсан хүндэт хөдөлмөрөөр (өнгөт уран зургаар) хаа хамаагүй хүний тансаг оршуулгыг зан үйлийн чанд өгүүлэмжээр хичээн дүрсэлж үлдээх боломжгүй нь тодорхой. Тиймээс энэ зураг нь “Чингис хааны оршуулга” гэж нэрлэсэн ёсоор хаан хүний, тэр дундаа Их хааных байх үндэстэй мэт. Зургийн бүтээгдсэн ерөнхий арга барил, уран чадвар нь эртний Перс зураг гэдгийг магадтай илэрхийлэх бөгөөд хүмүүсийн нүүр царай, харцны байдал болон толгой, гар, хөлийн харьцаа зэргийг бүдүүн тоймоор дүрсэлсэн (сэтгэл хөдлөл, нүүрийн хувирлыг тодорхой илэрхийлэхүйц нарийн уран чадвар харагдахгүй байгаа) нь Монголын үеийн перс иллюстрацийн эхэн үеийн (1310 оны орчим) бүтээл гэж үзэхээр байна. Гэхдээ зургийн үндсэн зохиомж, хүмүүс, үйл явдлыг хооронд нь төвөггүй зохицуулан дүрсэлсэн хийгээд орон зайн шийдэл, авсны тиг хэмжээ, алслалыг тодотгосон байдал, хувцасны хуниасыг дагнаасаар илэрхийлж, дээрээс өнгийж буй улаан өнгөт модыг (халуун орны модны хэлбэрийг Хятад зургийн аргаар дүрсэлсэн мэт) урласан чадвар зэргээс үзвэл тухайн цагтаа харьцангуй туршлагатай, уран зураач хүн уг түүхэн явдлыг сэргээн дүрсэлжээ гэж хэлж болно. Зурагт урнаар дүрсэлсэн ганц том мод (улаан өнгөт) нь бэлгэдлийн дүрслэл байж болохоос гадна Бурхан Халдун дахь үзэмжит ганц модны дор оршуулахыг Чингис хаан өөрөө үр ач нартаа захисан гэх сурвалжийн (Рашид-Ад-Дин, 2002: 377) мэдээтэй ямар нэг холбоотой байж мэднэ. Рашид-Ад-Дин нь “Судрын чуулган”-ыг эмхлэх ажлаа Ил хаадын нөлөөн дор хийж байсан тул тэр цагийн өрнө, дорнын хамгийн авьяаслаг зураачдыг “хаадын түүх” бүтээхэд дайчлан аваачиж байжээ. Тиймээс энэ зураг нь алтан ургийнханы ямар нэг домог хууч, баримт зэргээс үндэслэн, үгүй ядахад тэр үеийн монголчуудын оршуулгыг сонссон уран хүн зурсан нь дамжиггүй тул Чингис хааны авс (алтан товруу бүхий битүү чимэгтэй) ямар байсан тухай хамгийн эртний нүдэнд үзэгдэх мэдээлэл байж болох юм. Зураг нь 1227 оны эцэс, Хааны шарилыг эх нутагт (байгальд) нь намар цагт онголохоор зан үйл хийж байгаа сүүлчийн мөчийг дүрсэлсэн мэт. Оршуулгын олон зан үйлийн дотроос зөвхөн салах ёс гүйцэтгэх буюу гашуудах (уй хийх) мөчийг энд харуулжээ гэж хэлж болно. Зарим түүхэн сурвалжуудад монгол хаадын оршуулгын тухай бичихдээ “алтан авс, ... алтан хайрцаг, алтан хүүр,.. алтан шарил... алтан эдлэл хийх...” зэргээр дээдэлж бэлгэдэн өгүүлсэн ба үлэмж баялаг сан хөмрөг бүхий их хаадын авсыг бэлгэдэл, хүндэтгэл, ёс заншлын үүднээс алтаар чимэглэх, бүтээх боломжтойг харгалзан, мөн чимэглэл зурагт алтлаг шар өнгөөр дүрсэлсэн зэргээс үндэслэн хаадын нууцлагдсан оршуулгад авс хэрэглэсэн аваас тэр нь алтан тоног хийцтэй байх боломжтой хэмээн үзэж болно.

Уламжлалаар бол эртний монголчуудын оршуулга бүр австай байгаагүй, язгууртан хүнийг л авсанд хүндэтгэн залж оршуулах уламжлал голлож байсан гэж үзвэл зохилтой. Тиймээс авс хэрэглэх нь нэг ёсондоо хүндэтгэлийн оршуулгын хэлбэр

болно. Жирийн монгол хүнийг ил тавих (авсгүйгээр оршуулах нь хожмоо бүр их дэлгэрсэн. Зохиогч) ба авсгүй энгийнээр булшилж байгаль дэлхийд нь шингээх явдал бол эртний ертөнцийг үзэх үзэл, мөн нүүдэлч ахуйтай холбоотой (саяхан болтол уламжилж ирсэн) түгээмэл заншил юм. Зарим судалгаанд "...хүрэл зэвсгээс эхлэн түүхийн олон үед хамаарах булш оршуулга арвин ихээр олддогийн дотор чухам дундад эртний монголчуудын булш харьцангуй ховор байдаг нь...оршуулгаа...нарийн чанд нууцлан үйлддэг..."-тэй (Баяр, 1999. 6) холбоотой байж болохыг тэмдэглэсэн нь зарим талаар үндэстэй боловч гол шалтгааныг авсгүй, энгийнээр оршуулдаг нийтлэг уламжлалтай холбон үзэх нь илүү бодтой болно.

Чингис хааны оршуулга (Зураг 2)

Монгол оршуулга. XIV зуун. Тебриз(!). Иран. Шунх, шороон будаг, цаас. (Хэмжээ 19.6 x 26.5 см). Герман. Берлиний Улсын номын сан. Пруссын соёлын өв, Дорно дахины тасаг. Diez А у. 71, s.55

“Чингис хааны оршуулга” хэмээн нэрлэж хэвлүүлсэн энэ гар зургийн хуулбар (Мэнэс, 2008) бол хаан дээдсийг тэнгэрт хальсны дараа үндсэндээ ордны дотор болж буй гашуудлыг Европжуу зургийн нөлөөтэйгээр дүрсэлсэн өгүүлэмжтэй олдвор болно. Энэ зураг анх ХБНГУ-д нээгдсэн “Чингис хаан, түүний өв”(Dschingis khan und Seine Erben, 2005) олон улсын үзэсгэлэнд “Монгол оршуулга” нэрээр дэлгэн тавигдаж олны хүртээл болсон ба уг үзэсгэлэнгийн товёог номонд (каталогт) хэвлэгджээ. Уг товёогт тэмдэглэснээр энэ зураг Туркийн Топкапийн ордны цуглуулгаар дамжин ирж Германы Дийзийн өв санд хадгалагдаж байгаа перс зураг аж. Зургийг бүтээсэн цаг үе нь 1330-аад он гэх бөгөөд Зураг 1-ээс хожмын бүтээл, эсвэл түүний баяжуулан өөрчилсөн хуулбар байж болох нь зарим эд өлөг, дүрслэл зэргээс мэдэгдэнэ. Ил хаадын улсын түүхэн судруудын хуудасны дундаж хэмжээтэй харьцуулбал уг зураг нь хуудасны талыг эзлэх хэмжээний томхон талбайд, маш тодорхой өгүүлэмжтэй бүтээгджээ. Энэ мэт зургийн хэмжээ, агуулгаас үзэхэд номыг чимэглэж гоёх зорилготой бичил бүтээл (миниатюр) гэж хэлэх аргагүй юм. Харин түүхэн үйл явдалыг ухамсартайгаар хуулан, нарийн бодож дүрсэлсэн зан үйлийн баримтат дэлгэц, томхон бүтээл гэмээр. Энэ нь болсон үйл явдлыг хойч үед тодорхой үзүүлэн харуулж, тайлбарлан үлдээж байна.

Номын иллюстраци зургийн эртнээс уламжилсан зорилго нь бичмэл агуулгыг үзүүлэн хэлбэрээр харуулах явдал юм. Эрт цагт түүхэн судрууд нь нууцлан хадгалах, өвлөн үлдээх зорилготой үнэт зүйл болж байжээ. Гял цал, өнгө солонго, хээ чимэг гэхээс илүүгээр түүхийн амьд, үнэн дүр төрхийг сударт үлдээх нь Рашид-Ад-Дин нарын зорилго байсан гэдэг нь одоо нэгэнт илэрхий болсон юм. Тиймээс эртний перс түүхэн үйл явдлын зургууд нь чимэглэх зорилго багатай байжээ. Перс номын чимэглэл зургийн тухайд авч хэлбэл, анхны гар бичмэл судруудад чимэглэлийн (миниатюр) аяс хэлбэртэй бүтээгдэж байснаа хожмын хуулбаруудад үзүүлэн таниулах (хавсралт зураг ба тайлбар зураг гэхээр) өнгө агуулгатай, томхон хэмжээтэй зургууд болж хувирчээ гэлтэй байдаг. Тиймээс эхэн үеийн уугуул-чимэглэх зургууд (миниатюр) жижигэвтэр хэмжээтэй, ур дүрслэл энгийн байдаг бол хожмын хуулбар таниулах зургууд (иллюстраци) нь томхон хэмжээтэй, ур чадвар нь нарийссан, тийм боломжтойгоор бүтээгдсэн мэт ялгаатай тал ажиглагдаж байна.

Зураг нь Үйл явдал, зан үйлийн хувьд ерөнхийдөө Зураг 1-тэй төстэй боловч гол ялгаа нь Хаан, Хатаны ор сэнтийг зургийн төвд (оршуулгад) дүрсэлжээ. Ил хаадын номын иллюстраци (үзүүлэн) зурагт хааны ордон, төрийн ёслолыг харуулахдаа дүрсэлдэг онцлох эд хэрэглэгдэхүүнийг (сэнтийг) энд гол өгүүлэмж болгон илэрхийлсэн нь зайлбаргүй шалтгаантай гэж хэлж болно. Ил хаадын үеэс л перс гар зурагт төрийн ёслолд хаан оролцохдоо ийм хэлбэрт сэнтийд (хаан, хатан хамтдаа суух өргөн аравч бүхий сэнтий нь хоёр талдаа хагас өнцөглөсөн хаалттай, уртааш туушид нь бөөрөнхийлсөн зөөлөвч суудалтай) заларснаар түгээмэл дүрсэлж ирсэн ба сэнтийг оршуулгын ёслолын гол “дүр”-д зурснаараа уг гашуудал нь хааны (язгууртаны) оршуулга гэдгийг шууд илэрхийлжээ гэж үзэж болно. Улсын эзнийг (гар зурагт) онцлон илэрхийлэх гол эд зүйлийн нэг нь Хаан сэнтий юм. Энэ нь төрийн ёслолыг харуулсан Перс судрын зургуудад ажиглалт хийх явцад батлагддаг. Мөн уг зургаас орчны зүг чигийг тодорхойлж болохоор байна. Авсны толгойн хэсэг нь аль зүг рүү чиглэж буйг мэдэгдэхүйц дүрсэлсэн ба зүг чигийг тогтооход авсыг залсан сэнтий “тусалж” байна. Авсны толгойн хэсэгт буюу баруун зүгт нь эрчүүд зогсчээ. Нийт 23 хүн дүрслэгдсэнээс олонхи нь эрчүүд байна. Бүгд бараан өнгийн хувцастай, бүгд үсээ мөн л задлан (малгайтай хүн үгүй, бүгд зэр зэвсэг, гоёл зүүсгэлгүй) гашуудал үзүүлнэ. Хааны шарилыг зургийн хойморт (хүмүүсийн зогсох байрлалаас үзвэл ордны хоймор гэж үзэхээр) байрлах сэнтий дээр залжээ. Ордны доторх байдлыг (орчныг) илэрхий тодорхой дүрслээгүй байна гэж үзэж болно. Дээдсийн залардаг сэнтий дээр шарилыг залсан нь хаан хүний хойдохын ёслол гэдгийг баталж байна (тэр үеийн Ил хаадын улсад олон захирагч, удирдагчид байсан боловч зөвхөн Хаан, хатан хоёр л ийм сэнтийд заларч байжээ!). Авсны дээр хучлага тавьжээ. Хучлаганы нэг хэсгийг ярж авсыг ил гаргаснаар дүрсэлсэн байна. Хучлаганаас цухуйх дүрслэлээс үзэхэд авс нь нилээд эрхэмсэг, уран хийцтэй ажээ. Авсны тагийг уртааш уран бөмбөгөр хэлбэрээр шийдэж, хөвөө эмжээрийн төгсгөлийг дээш угалзран (дорнын уран барилга мэт) төгссөн байдлаар, мөн авс нь хажуу төгсгөлд (толгойн хэсэгт) бяцхан гэгээвч мэт зүйлтэй байгаагаар илэрхий дорнын аястай зуржээ. Сэнтий болон авс, сэнтийний хөл, булан зэргийн угалзарсан сийлбэр зэрэг дүрслэлийг ажихад энэ нь монгол хээ, хэлбэр, урлал модон хийц гэдэг нь мэдэгдэм харагдана. Эрчүүд нь гараараа өвчүүгээ дарж (цээжээ дэлдэх), ташуу захтай дээлийн энгэрийг задгайлан (энгэрээ ярах), мөн бүгдээр хөмсгөө атируулан (тод харуулсан) гашуудлаа илэрхийлж байна. Зарим нь үсээ үгтээн (толгойгоо барин) гашуудаж байхад, зарим нь гараа дээш алдлан өргөж, зарим нь алчуураар нулимсаа арчиж байгаагаар зурж харуулжээ. Эл бүхий зан үйлээрээ, мөн үйл явдал, зохиомжоороо Зураг 1-тэй адил төс байна. Сэнтийд залсан шарилын өмнө доод талд сан утлагын бойпор мэт нэг зүйл савд зориулан явган ширээ тавьсан харагдана.

Ширээний дэргэд (зургийн төв доод хэсэгт) гурван эр зогсоод гашуудлын өөр өөр зан үйлийг үйлдэх мэт байна. Энд нэг эр хоёр гараар энгэрээ ярж, хөмсгөө атируулан, харин түүний өөдөөс нь харж зогсоо эрчүүд хоёул (үсний задгайлсан байдал нь бусдаас онцлог сүртэй) ямар нэг юм хэлж байх мэт амаа ялигүй ангайж

(хашгиран их дуугаар гашуудах зан үйл ч байсан аж), мөн нэг нь гараа алдлан дээш өргөсөн байгаа нь анхаарал татна. Энэхүү хоёр эрэгтэйн үсний задгайлсан байдал нь бусдаас онцлог сүртэй (ялгаатай) дүрслэгдсэн ба зогсож байгаа байршил нь нэгэн тусгай зан үйл хийж буйг илтгэнэ. Төв Азийн зарим нүүдэлчдийн оршуулгад “гэгэх” ёс (ёс үйлдэгчийг “гэгээч” гэдэг байж. Зохиогч) буюу бүрлээчид хандаж гашуудан шүлэглэх, хайлан ухилан аялгуулах, дуулах зан үйл өдгөө болтол уламжилж ирсэнийг уг үйлдэл сануулж байна. Эртний Монголчууд ч бас тийм заншилтай байсан гэх мэдээ бас бий. Нас барагсдын оршуулга дээр бөө тамлага хийх ёс ч байсан гэдэг. Нэрт эрдэмтэн Х. Пэрлээ “... булш дээр нь хэлэх үгийг эрхэмлэх заншил монголчуудын дунд мөн дэлгэрсэн байна. Жишээ нь: “Өргөн сайхан голоо сүндэлж, Өндөр сайхан хушуугаа дамжиж яв...” гэх буюу “Халих харцагын жигүүр болон одов уу, Хангинах тэрэгний тээш болов уу чи” гэх мэт буюу. Тийм зан үйл, сүүлчийн үе хүртэл үргэлжилсэн бололтой, үхэгсдийн толгой дээр “срөөл” унших зан үйлийн нөлөө бололтой” (Пэрлээ, 1956) гэжээ. Үүний нэг жишээг зурагт амаа ангайсан хоёр хүнээр харуулсан байж мэдэх ба Чингис хааныг өөд болоход ч Гилгүдэй баатарын шүлэглэн хайлсан (Лувсанданзаны Алтан товч, 1990) нь бас нэг сэжим байж болно.


Зураг 2-ийн төвд дүрсэлсэн сэнтийний ард гашуудаж буй хоёр хүн, сэнтийний зүүн талд зарим эмэгтэйчүүд алчуур мэт толгойн өмсгөлтэй шарилд ойртож гудайн сууцгаажээ. Энэ нь “Эхнэрүүд богтаг малгайнхаа оройг салгаж бэлэвсэрч байв” (Эрдэнэбат, 2006) гэсэн дүгнэлтийн нэгэн жишээ (эмэгтэйчүүдийн толгой дээр үзэгдэх алчуур мэт зүйл нь богтаг малгайн хэсэг) байж болох юм. Эмэгтэйчүүд мөн илүүтэй ихээр гашуудаж байна. Зурагт дүрслэгдсэн дүрүүд, хүмүүсийн тоо хэмжээ нь тодорхой учир шалтгаан агуулсан эсэхийг уг дүрслэлээс таамаглаж хэлэх боломж бага юм. Перс судрын зургаас үзэхэд, гашуудал ба төрийн ёслолд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн зогсох байршил адил төстэй ба харин гашуудалд цөөн хүн оролцож (дээл хувцсандаа элдэв зэр зэвсэг, гоёл зүүсгэлгүйгээр хоосон) байсныг мэдэж болно. Ямар ч атугай энэ зураг нь Монголчуудын оршуулгын талаар тодорхой эх сурвалжаас үндэслэсэн нь илт байна.

Мөн энд оршуулгын зан үйлийг харуулахдаа, зарим Перс (XIV зууны) гар зургуудад Ил хаадын төрийн ёслолын тухай (язгууртны оршуулга ч төрийн ёслол билээ. Зохиогч) зурахдаа хааны сэнтийд хааяа нэг харагддаг өвөрмөц бэлгэдэлийн эд зүйлийг дүрсэлсэн нь анхаарал татаж байна. Энэ нь сэнтийн дээр залсан цэцгэн хэлбэртэй биет зүйлийг мөн авсны тэргүүнд адилхан залсан байгаа явдал. Энэ бэлгэдэл нь сэнтийний эзэн буюу хаан язгууртан өөд болсныг хэлж өгч байна. Ажиглахад, лянхуа (цацаргин) цэцэг байж мэдэхээр ба уг дүрслэл нь мөнхүү зурагт хожуу үеийн нөлөөтэй бүтээл, эсхүл хятад дорны бэлгэдлийн нөлөө орсныг даруй нотолж байх мэт. Лянхуа мэт цэцэгсийг мөн Монгол (Юань гүрний) оршуулгын бунханы туурга, хананы зарим зурагт дүрсэлсэн байх нь хааяа тааралддагийг үүнтэй холбон авч үзэж болно. Зураг 2 нь зохиомж, агуулгын хувьд ч Зураг 1-тэй нилээд төстэй байна. (Эртний Ил хаадын монголчууд түүхэн бичлэгийг жил бүр цөөн

тоогоор хувилж, мөн орчуулж, баяжуулж, алдаа мэдгийг засаж хуулбарладаг байсныг дашрамд анхааран үзэх хэрэгтэй!).

Сэнтийн дээр, авсны дор байх бөөрөнхийлсэн хэлбэртэй суудал зөөлөвч (хаан, хатаны суудал) үзэгдэх нь уг зургийг бүтээхдээ Перс эд өлөгийг дүрслэх иллюстрацийн түрүү үеийн өгүүлэмжийг хэвээр баримталсан байх хирнээ булангийн сийлбэр, хээ зэрэг нь перс номын зургуудын ууган эхүүдэд төдийлөн элбэг тохиолддоггүй биет, томруун угалзан (монгол) дүрслэл хэрэглэсэн нь уг зургийн бүтээгдсэн үеийг илэрхийлж байна гэж үзэж болно. Мөн сэнтий, авс, явган ширээний алслал, модон хийц хөндлөвчүүдийн гэрэл, сүүдрийг өнгөний хүчдэлээр (температураар) илэрхийлсэн байдал болон авсны доор дээр байгаа хучлага, хүмүүсийн дээлийн хуниас зэрэгийг бие бодот томруун (хавтгай зургаар бус рельеф дүрслэлээр) төрхөөр зурж харуулсан, ерөнхийдөө бийрийн бичлэгийн тоочилт багатай, мөн гашуудагсдын сэтгэлзүйг дүрслэхдээ оролцогчдын харц бүгд гунигтай бөгөөд хөмсгөө зангидаж, зарим нь духаа атируулсан зэрэгээр харьцангуй реалист аястай зурсан зэрэг нь дундад зууны Европ уран зургийн “сургууль”-д илүү ойр болохыг илтгэнэ. Нөгөөтэйгүүр дүрслэлийн ийм харьцангуй нарийн ур чадвар нь (зураг нь) судрын хуудасны талыг эзлэх хэмжээнд томхон талбайд, номыг зөвхөн чимэглэх бус үйл явдлыг дүрслэх гол зорилготой зурагдсантай холбоотой байж болно. Яг энэ зургийн дүрслэлийн хэлбэр, урлах арга барилыг санагдуулам зохиомжоор төрийн ёслолыг харуулсан (нэн адил онцлогтой) зургууд Перс номын үзүүлэн таниулах дүрслэлд цөөнгүй тааралддаг нь тухайн үеийн нэг л зураачийн гараар эдгээр адилхан “ажил”-ууд бүтээгджээ хэмээн дүгнэж, ялган таньж болохоор байдаг. Иймэрхүү үндсэн онцлогтой зургуудыг Ираны Тебризийн(?) “сургууль”-д бүтээгдэж, өнөөдөр Герман дахь Дийзийн цуглуулгад хадгалагдаж байгаа өвүүд голлон тодорхойлж байна гэж хэлмээр. Тебриз(?) -Дийзийн өвүүд онцгой уран байдлаараа (Топкапийн цуглуулгад хааяа адил арга барил тааралдана) бусад хадгалагдан үлдсэн өвүүдээс ялгардаг. Судлаач Шэйла С.Блэйрийн хэвлүүлсэн (Blair, 1995) гайхалтай судалгаанд эдгээр төрийн ёслол бүхий зургуудыг 1330-аад оных гээд “Судрын чуулган”-ы гар бичмэлээс салгаж авсан байж болохыг тэмдэглэжээ. Мөнхүү арга барилаар гүйцэтгэсэн түүхэн зургууд нь “Судрын чуулган”-аас тусдаа зурагдсан (нэг зураачийн гараар. Зохиогч) ч байж болох бөгөөд уг зураач нь Их Монголын “Шах намэ” (ард үз!. Зураг 4) судрыг бүтээх үйлсэд ч оролцож “Исфандиерийн оршуулгын цуваа” зургийг бүтээсэн байж тун магадгүй гэж бодогдохоор байдаг. Энэ нь ижил хэмжээний томхон талбайд үйл явдлын чөлөөтэй уран дүрслэлийг багтаан зурсан байдаг. Нэр нь үл мэдэгдэх зураачийн яг ийм арга барилаар, тухайн үеийн Ил хаадын улсын (Монголын) төрийн ёслолыг дүрсэлсэн харьцангуй томхон хэмжээтэй олон баримтат (!) зургууд бүтээгдэж байсан нь энэхүү оршуулгын зан үйлийн зургийн онцлогтой мөн давхцан харагдаж байх мэт санагдана. Мөн эндээс нэгэн сонирхолтой сэжиг таамаг ажиглагдаж байгаа нь уг зураач ба зурахад холбоотой байсан хүн нь он цагийн хувьд Өлзийт (1304–16) ба Абу Сайд (1317-1334) хоёр монгол хааны оршуулгын ёслолд оролцсон гэрч байж болохоор байна. Персийн иллюстраци зургуудыг Ил хаадын үед зарлигаар

бүтээхдээ олон бүс нутгаас зураачид авчирч байсан тул аажимдаа тэдний дүрслэлийн арга барил болон соёлын ялгаа, иргэншлийн онцлог (Хятад, дорно дахин, Европ уран зургийн нөлөө) нь өөр хоорондоо харилцан нөлөөлж хөгжсөн нь илэрхий ажиглагддаг. Зураг 2-т эдгээр нөлөө харилцан туссан ч Европ хандлага давамгайлжээ гэмээр.



Зураг 2. Чингис хааны оршуулга

Сэнтийний аравчны дээд хэсэг ба утлагын (?) ширээний доод хэсэгт тухайн үеийн будгаар (бэх байж болно?) бололтой араб хэлээр “султан...хаан...” гэх мэт хэдэн үгийг бичээд дээрээс нь балласан байна (!). Тэгэхээр баларлаг бичээс нь уг зургийг перс бус араб хэлний “Судрын чуулган”-аас, тэр дундаа ялигүй хожуу үеийн хувилбараас улбаатай гэдгийн бараг нотолгоо болж байна.

Чингисийн оршуулгын цуваа (Зураг 3. Энэтхэг зураг)

Чингисийн оршуулгын цуваа. Рашид Ад-Дин “Судрын чуулган”-ны нэгдүгээр ботийн гар бичмэл. XVII зуун. “Китаб-и Чингиз намэ”(Чингисийн түүх) хэсэг. Их Моголын ордон.

“Чингисийн оршуулгын цуваа” (Map, 2004) хэмээх энэ зураг нь XVII зуунд Энэтхэгийн Их Моголд зурагдсан бөгөөд Чингис хааны оршуулгын тухай Марко Пологийн түүхэнд үндэслэн Акбар хааны зарлигаар ордонд бүтээгдсэн судрын зургийн нэг бололтой. Зургийн хэмжээ, оршин буй судрын талаар мэдээлэл одоогоор бага байна. Зургийн гүйцэтгэлээс үзвэл томхон хэмжээний тайлбар үзүүлэн зураг байх боломжтой. Их Моголын хаадууд Чингис хааны хожмын ураг төрөл байсан бөгөөд тэдний хувьд алтан ургийн гэр бүлд үе дамжин нууцлагдаж ирсэн Домогт хаадын түүхийг бүтээхдээ ийнхүү зуруулжээ.



Зураг 3. Чингисийн оршуулгын цуваа (Энэтхэг зураг)

Зургийн үйл явдал, зохиомжийн хувьд, Их хааныг тэнгэрт хальсны дараа эх нутаг руу нь шарилыг зөөсөн гэх түүхэн сурвалжийн адал явдалт мэдээг хожуу үеийн Энэтхэг (Их Могол) уран зургийн арга барилаар уран чадмагаар дүрслэн харуулжээ. Зургийн гол дүрслэл, үйл явдал, хувцас хэрэглэл, бялтат буу зэвсэг, морьдын хуяг, заант цэрэг зэрэг нь жинхэнэ монгол төрх бус харин XVII зууны Их Моголын угсаатны төрхийг хуулсан байдлаар бүтээгджээ. Зураг 1-тэй адилсгах зүйл нь Чингис хааны авсыг мөн алтаар (шаргал өнгөөр алтан хийцийг илтгэжээ гэж үзэж болно. Зохиогч) хийсэн хэмээн дүрсэлсэн бөгөөд авсыг нарийн уран сийлбэр

бүхий алтаар (алтлаг өнгөөр зурсан) битүү хээлэн урлаж, эрдэнийн чулуун шигтгээнүүдээр чимэглэсэн байна. Дүрслэлийн хувьд XVII зууны Энэтхэгийн онхи өөр амьдралыг хуулсан, цэргүүд авсыг мөрөн дээрээ тавиад тээж, буутай цэргүүд, мөн морьтнууд дагалдан яваа зэрэг нь гэнэн хэдий ч “алтан хайрцаг”-ийг дүрсэлсэн байдал нь эртний сурвалжтай төс байгаагаараа, мөн Их Моголын сурвалжтнуудын өв дурсгал гэдгээрээ, хаадын тухай түүхэн бичлэгт Моголчууд Рашид-Ад-Диний чимэг зургийн арга ба өвийг баримтлан уламжилж авсан гэдгээрээ анхаарал татаж байна.


Монгол гашуудлын зураг (Зураг 4).

Исфандиерийн оршуулгын цуваа. Эх. Их Монголын “Шах Намэ” (Хаадын судар), 1330-аад он. Иран, Тебриз(?). Цаасан дээр бэх, усан будаг, алтаар зурсан; (хэмжээ 22 x 29 см). 1933 оноос Жозеф Пулицер Бекуестийн цуглуулгад. Нью-Йорк. Метрополитан.


Энэ бол XIV зууны Перс (Ил хаадын) зураг юм. Зан үйлийн өгүүлэмжээрээ онцгой, дүрслэлээрээ уран аж. Ил хаадын үеийн Персийн тансаг чамин гар бичмэл болох “Хаадын судар” (Shah nama) буюу одоогийн нэрээр Их Монголын “Шах Намэ” хэмээх баатарлаг туульсын сударт энэ зураг үлджээ. Гхяат-Эд-Дин хэмээх хүн 1330-аад он хүртэл уг судрыг бүтээх (анхны чимэглэл зурагтай эх) ажлыг Тебриз хотод удирдан хийлгэсэн гэдэгтэй ихэнх судлаачид санал нэгддэг. Гхяат-Эд-Дин нь Монгол язгууртнуудын дэргэд сууж дэлхийн түүхийг бичиж асан Рашид-ад-диний хүү байжээ. Энэ зураг нь Чингис хааны оршуулгатай шууд холбоогүй боловч дундад эртний монгол язгууртны оршуулгын зан үйлийг нүдэнд харагдах аргаар бүтээсэн эртний түүхэн шинжтэй нандин олдворын нэг гэж хэлж болно. Хааны оршуулгатай холбоотой зарим зүйлсийг эндээс баримжаалан харж болох ба бусад мэдээллийг ч нягтлахад энэ үнэмшилтэй сурвалж нь чухал хэрэглэгдэхүүн болж чадна. Перс судрын энэхүү зурагт туульсын баатар удирдагч Исфандиерийн шарилыг Иран руу тээж яваа домгийг дүрслэхдээ монголчууд язгууртнаа оршуулж байгаа (шарил тээж яваа) ёслолыг яг тэр хэвээр нь хуулбарлан харуулснаараа онцлог гэж судлаачид тэмдэглэжээ. Гашуудлын цувааны эхэн хэсэгт тод улаан худрага, хазаар зэргээр чимэглэсэн бараан зүсмийн морь (Исфандиерийн морь) хөтөлсөн эр тэргүүлэн явж, эргэж харна. Шарил тээхэд хоёр илжиг (эсвэл луус мэт) ачаалж, мөн өөд болоочийн хүлгийг (намхан монгол морь) бөө зайран (?) хөтлөн явна. “Гашуудлын тэмдэг болгож Исфандиерийн морины дэл, сүүлийг хяргажээ. Эмээлээс нь баатрын таяг (шийдэм. Зохиогч), саадаг, дуулга зүүсэн байна. Тэнгэрийн сүнсийг төлөөлж гурван галуу, мөн үүлсийг дүрсэлсэн байдал нь Хятад зургийн уламжлалаар урлажээ” (www.metmuseum.org/toah/ho/07/wai/ho_33.70.htm. October 2006). Оршуулгад оролцож байгаа бусад хүмүүс бүгд шарилын цувааг явганаар дагаж, цайвар өнгийн (янз бүрийн өнгөтэй байгаа нь мэдэгдэж байгаа) хувцас өмсөцгөөсөн мэт харагдана. Үнэндээ бол Монголчууд оршуулгад бараан хувцастай дүрслэгдсэн (Зураг 1, Зураг 2) өнгө аясыг мөн энд адилхан зуржээ гэж хэлж болно. Учир нь зураг дээр өмссөн ташуу захтай дээлүүд нь цайвар өнгөтэй мэт

харагдах боловч хувцасны өнгийг зурахдаа дагнаас өнгөөр (битүүлж будах бус) илэрхийлснийг ойлгож ажиглавал хүмүүс ерөнхийдөө бараан хувцастай аж. Зургийн төвд дамнуурга мэт зүйл дээр тээж яваа удирдагч язгууртны (Исфандиерийн шарил) авс (гоёмсог хээтэй хоргойгоор хучсан, домгийн ёсоор бол энэ нь төмөр авс) нь дүрслэлийн үйл явдлын төв болж байна. Авсны дамнуургыг морьдын (луусны) нуруун дээр даруулж бэхэлжээ. Авсны дээр монгол язгууртны хэрэглэдэг исэр сандлыг бэхэлж, мөн Ил хаадын монгол эрсийн гоёлд түгээмэл хэрэглэж байсан (перс миниатюрт олонтаа дүрсэлсэн байдаг) шар шувууны өдөөр битүү чимэглэсэн, шилэвч бүхий монгол малгайг түүний дээр нь бэхэлжээ.

Авсны толгойн хэсэгт мөн л (Зураг 2-той адилаар) бэлгэдэл зүйлийг тавьсан харагдана. Ургамал ногоо цэцэглэсэн нутаг болохыг бас (Зураг 1-ийн адил) харуулжээ. Оршуулгын цувааг дагалдагсад бүгд монгол уламжлал ёсоор үсээ задгайлж (бүгд малгайгүй) гашуудан явцгаах (Зураг 1, Зураг 2-той адил) бөгөөд гашуудлын зан үйлийн янз бүрийн хэлбэрийг тэдний хөдөлгөөн нь илэрхийлж байгаагаар дүрсэлж үлдээжээ. Гашуудлын үеэр үсээ задгайлах зан үйлийг зориуд тодотгон бусад дүрслэлээс илүү сүржин гэмээр зурагт харуулсан нь энэ зан үйл нилээд хүчтэй сэтгэгдэл төрүүлдэг байснаас болсон байж болох юм. Энэ зураг нь дүрслэлдээ зарим гашуудагсад мууран унаж, цурхиран балартах агаад заримыг нь хажуунаас нь тэвэрч дэмнэж байгаа бол, заримыг нь хажуунаас түшиж уй гашууг нь хуваалцаж, түшилцэн яваагаар сэтгэл хөдлөлийг харуулснаараа онцлог. Ингэж эртний монголчуудын шарил тээх (залах), гашуудах зан үйлийг тод хөдөлгөөнтэй дүрслэхдээ угсаатны эд хэрэглэл, дагалдах зүйлсийг нарийн чадамгай, үнэн зурснаараа чухал юм. Гашуудагсад мөн гараа алдлан өргөх, цээжээ даран эмгэнэх, энгэрээ ярах зэрэг үйлдлээрээ энд ажиглалт хийсэн бусад зургуудтай адил байна. Зургийн зүүн доод өнцөгт анхаарал татах зарим онцлог байна. Бусдаас өөр тод өнгийн бүс бүсэлсэн хоёр гашуудагч (эр, эм) явах ба тэдний зүүн ханцуйд авсыг хучсан хоргойтой төс бүхий тууз уясан нь ялгарч харагдана. Зан үйлийн ямар учир шалтгаантай дүрслэл болохыг тайлбарлах мэдээлэл бидэнд одоогоор алга байна. Ташуу захтай дээл, өдөөр чимэглэсэн шилэвчит малгай, үсээ задгайлах зан үйл (малгайгаа авч), шарил дээр эд өлөг байрлуулах, цувааны эхэнд морь хөтлөх, гашуудлын ааш аягууд, бараан өнгөт хувцас зэрэг нь нилээд үндэстэй баримт болох бичмэл эх сурвалжуудыг баталж, мөн сонгон авсан перс зургуудтай (Зураг 1, Зураг 2-той адил) өгүүлэмж ижил байна. Гашуудлын зургийн дээд хэсэгт нисэх шувуу дүрсэлснийг “...Тэнгэрийн сүнснийг төлөөлж гурван галуу... Хятад зургийн уламжлалаар урлажээ...” (http://www.metmuseum.org/toah/ho/07/wai/ho_33.70.htm. October 2006.) гэж тайлбарласан нь бас сонин мэдээлэл юм. Энэ нь Өвөрмонголын Ордос дахь Аржайн 28 дахь агуйн зурагт (Чингис хааны оршуулгын ёслолыг харуулсан байх гэж хятадын судлаачид үзжээ) нисэж буй тогоруудыг дүрсэлсэнтэй бэлгэдэлийн хувьд тохирч байгаагаараа чухал юм. Монголчууд нас барагсдаа “тэнгэрт халих (нисэх), тэнгэрт одох” утгаар ойлгож ирсэн нь уламжлалд бий. Их хааныг нас барахад Гилгүдэй баатар гашуудан Чингис хааны шарилд хандаж хэлэхдээ (“гэгэх ёс”-той төс) “Халих харцгайн жигүүр болон одов уу чи эзэн минь...



Зураг 4а. Монгол гашуудлын цуваа. Исфандиерийн оршуулга. “Хаадын судар”-ын эх нүүр ба хэсгээс



Зураг 46. Монгол гашиудлын цуваа. Исфандиерийн оршуулга зургийн хэсгүүд

Тоглох харцагын жигүүр болон одов уу чи эзэн минь...Жиргэх шувууны жигүүр болон одов уу чи эзэн минь..." (Лувсанданзаны Алтан товч, 1990: 144) гэсэн байдаг. Энэ мэт нягтлан судлууртай зүйл бас байна.

Бидний ажиглалтад өртөж байгаа энэ зургийг "Исфандиерийн оршуулга" гэж нэрлэсэн ч Персид болсон монгол оршуулгаас сэдэвлэсэн болох нь тодорхой байна. Ираны алдарт туульсын баатрын оршуулгыг дүрслэхдээ тэр үеийн урчууд, судрыг бүтээгчид нь монгол оршуулгын зан үйлийг ашиглан, эх сурвалжид мэдээлсэн (Рашид-Ад Дин "Судрын чуулган") ёсоор зурсан нь сонин. Чингис хааныг тэнгэрт хальснаас зуу гаруй жилийн дараа ч түүний удам Абу Саид (1317-1334) хааны монголчууд Персийн соёлд нилээд ууссан хэдий ч оршуулгад өөрийн уламжлалт заншлаа эрхэмлэж байсныг энэ зураг гэрчлэн харуулж байж болох юм. Нөгөөтэйгүүр "Шах намэ" судрыг бүтээх нэр төртэй ажлыг удирдсан Гхяат-Эд-Дин нь монгол язгууртнуудын төлөөний хүн, түүхч, соён гийгүүлэгч Рашид-Ад-Диний хүү байсан гэдэг холбоо хэлхээг ч энд бас бодолцож үзэх хэрэгтэй юм.

Уран чадварын онцлогийн хувьд "Их монголын шах намэ"-ийн зургууд нь мөнхүү зургуудаас өмнөх үе буюу Газан хаан (1295-1304), Өлзийт хааны (1304-16) захирах үеийн перс уран зургаас нилээд хожуу, дэвшилттэй өнгө аясыг нотлох ба зураачид нь "...уламжлалт перс зурагт хувцас хэрэглэл, хад чулуу, модод, үүлс зэргийг дүрслэхдээ хятад зургаас хуулбарлах, зохиомжийн хувьд орон зай, алслал зэргийг зурахдаа өрнөдийн нөлөөг тусгаж байсан..." ба энэ нь "...Перс уран зураг (соёлын солилцоо, хөгжлийн нөлөөгөөр. Зохиогч) нэгэн шилжилтийн үедээ хүрээд байсныг нотолдог..." (http://www.metmuseum.org/toah/ho/07/wai/ho_33.70.htm. October 2006.) байна. "Исфандиерийн оршуулгын цуваа" зурагт соёлын нөлөөний дээрх өнгө аяс илэрхий туссанаас гадна "хувь хүний сэтгэл хөдлөлийг реалист аргаар тод илэрхийлсэн Персийн анхны бүтээлүүдийн нэг" (Carboni Stefano, and Qamar Adamjee. "Folios from the Jami' al-tavarikh (Compendium of Chronicles)". October 2003, [www.metmuseum.org/special/se_event.asp? OccurrenceId={36C74128-EEF8-11D5}](http://www.metmuseum.org/special/se_event.asp?OccurrenceId={36C74128-EEF8-11D5})) гэж үнэлэгдсэн байдаг. "Шах намэ"-гийн уран дүрслэлүүд нь Тебриз(?)-Дийзийн арга барилтай нэг үеийн бүтээл юм гэж хэлж болохоор байдаг.

"Шах Намэ" туульсын бүтээл нь Персийн алдарт найрагч Фирдоуси-гээс (1000 оны үе) эхтэй бөгөөд үндэсний туульс хэмээн үзэж иржээ. Харин уг туульсыг үнэ цэнэтэй байдлаар бүтээж, залж дээдлэх уламжлал нь Ил хаад буюу Монголын хаанчлалын үеэс бий болжээ. Тиймээс "Монгол Шах Намэ"-г алт, бэх, будаг хольж, машид тансаг, уран маягаар авьяаслаг зураачид бүтээжээ. "Их монголын шах намэ" нь 280 хуудас, 190 иллюстраци болон миниатюр зургаас бүрддэг. Энд орсон чимэг зургууд ч монгол угсаатны дүрслэлээр баян бүтээгджээ. Ийнхүү "Шахнамэ" дэх монгол оршуулга нь эртний бичмэл болон аман сурвалжууд, бодот амьдрал дээр үлдсэн зан үйлийг уран зургаар (харж үзэх баримтаар) нотолсон ховор чухаг нотолгооны нэг болж үлджээ.

Чингис хааны оршуулгын гашуудал (Зураг 5)

"Монгол хувцас уран зурагт" (Darnley, 2002) бичихдээ "Чингис хааны оршуулгын гашуудал" ("*Lamentation at the bier of Chingiz Khan*" from *Rashid al-Din's Jami' al-Tawarikh*") (Зураг 5а, Зураг 5б) нэртэй зургаас (хоёр хэсгийг) хар цагаан

өнгөөр хавсаргажээ. Рашид-Ад-Диний “Судрын чуулган”-аас авсан гэж тэмдэглэсэн уг сонирхолтой зургийн чухам эхийг магадлан мэдэх шаардлагатай. Зургийн бүтэн эх нь Чингис хааны оршуулгыг дүрсэлсэн бололтой. Зургийн хэсэгчилсэн энэ хоёр “тасархай”-гаас үзвэл мөн л угсаатны онцлог дүр төрхөөс гадна монгол зарим зан үйлийг ерөнхийд нь бусад дүрслэлтэй (Зураг 1, Зураг 2, Зураг 6-ын адилаар) адилавтар зурсан хэдий ч илт ялгарах зүйл бас байна. Зураг 5а нь эрчүүдийн талыг дүрслэн харуулахдаа эрчүүд малгай, тоног бүхий бүстэйгээ (ажиглалт хийсэн бусад зургаас гоёлын бүсийг илүү тод харуулжээ), нэгэн сурвалжит бололтой хүн ихэмсэглэх мэт зургийн төв доод хэсэгт исэр сандал дээр суусан байгаа нь илт ялгарах онцлог байна. Энэ нь гашуудал үйлдэхдээ зарим нь малгайтайгаа (гоёлын бүстэйгээ) ёслолыг үйлддэг гэсэн үг хараахан биш байх. Харин гашуудлын ёслол нийтээр өрнөхийн өмнө, хойно мөчүүд ба зарим эмгэнэлд оролцогчид ёслолоо хараахан эхлээгүй хугацаа зэргийг харуулсан, эсхүл зураачийн ташаарал (?) байж мэднэ.




Зураг 5. Чингис хааны оршуулгын гашуудал

Мөн “Түүнчлэн эзэн хааныг үхмэгц малгайн орой дахь өдөн чимэглэлийг авч уй гашуудал болох ба...” (Эрдэнэбат, 2006: 119) гэх мэтээр тэмдэглэсэн нь гашуу тайлах цаг хугацааны туршид (зарим сурвалжид хоёр жил гашуу тайлсан гэдэг) үргэлжлэх зан үйлийн хувьд л ийн хэлж буй бололтой ба энэ нь салах ёс гүйцэтгэх (уй хийх) мөчид малгайтай байдаг гэсэн үг биш гэж үзнэ. Дээр эшэлсэн “...малгайн орой дахь өдөн чимэглэлийг авч уй гашуудал болох...” гэдэг гашуудалд гоёл зүүсгэлийг цээрлэдэг болохыг дам хэлж өгч байгаа баримт юм. Гашуудан сөхөрч суусан бүсгүй хүн (толгойдоо алчуур мэтийг боосон) алчуураар нулимсаа арчина (Зураг 5б). Оршуулгад оролцогчдын зогсох (гашуудах) байршлыг монгол оршуулгын тухай үзүүлэн (чимэглэл) зургуудад тодорхой дүрсэлснээс үзэхэд шарилын зүүн талд эмэгтэйчүүд байгааг нотолж байна. Зураг 5а, Зураг 5б-д үндсэн зургийн төвд дүрслэгдсэн сэнтийний булангууд (сэнтийний аравчнаас хонх унжина) цухуйж байна. Шарил буюу авс нь зургийн төв дээд хэсэгт байгаа бололтой. Энэ

зурагт Перс зураачийн олж харсан, эсвэл сонссон, төсөөлсөн, хуулбарласан монгол гашуудлын нэг гэдэг нь тодорхой байна. Дүрслэл, уран чадварын хувьд авч үзвэл Ил хаадын ноёрхлын дунд үе буюу Рашид-Ад-Диний цуглуулгын эхэн үеийнх байх нь магадтай бөгөөд “Судрын чуулган”-ы зарим хуулбараас авсан байх боломжтой.

Дээдэс язгууртны оршуулга (Зураг 6)

Монголчуудын оршуулгын зан үйлийг харуулсан Перс номын чимэг зургийн хэсэг. Тебриз(?). Иран. 1310 оны орчим. Парисын Үндэсний номын сан. Paris, Bible. Nation. Supple pers. 1113.



Зураг 6. Дээдэс язгууртны оршуулга

Сонин онцлогтой нэгэн Перс зургийг доктор У.Эрдэнэбат “Монгол эхнэрийн богтаг малгай” (2006) нэг сэдэвт бүтээлд хавсарган хэвлүүлжээ. Хар, цагаан өнгөөр хэвлүүлсэн уг зураг нь монголчуудын үсээ задлан гашуудах зан үйлийг тод тусгаагүй мэт байна. Энэ зургийн бүртгэлийн дугаараас (*Paris, Bible. Nation. Supple pers. 1113*) үзвэл Зураг 1-тэй хамт Парисын цуглуулгад хадгалагдаж байгаа аж. Гэвч адил агуулгатай хирнээ дүрслэл, эд өлөг, зан үйлийн зарим ялгаанаас ажиглавал энэ хоёр зураг шууд хамааралгүй мэт. Харин энэ зураг нь Зураг 5-тай хуулбар (хувилбар)-ын илүү ойр холбоотой байж болохоор байна. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гашуудал илэрхийлэх байрлал нь (Зураг 1) ба (Зураг 2), (Зураг 5), (Зураг 6)-тай адил байна. Хүндэтгэлийн сэнтийг гадаа (байгальд) гаргаж тавьснаар дүрсэлсэн ба түүний дээр авсны байрлал, хэлбэрээс (шарилын цээж, толгойн хэсэг рүү авс өндөрсөж, өргөссөн байдаг) харвал толгойн хэсэг нь эмэгтэйчүүд рүү буюу зүүн тал руу харсан гэж үзэхээр онцлогтой байна. Энэ нь дээр дурдсан зургуудаас авсыг өөрөөр (өөр чиглэл рүү харуулж) байршуулсныг илтгэж байна. Үүгээрээ хааны хатан ба мөн хаан ширээ залгамжлах хан хөвүүд мэт зиндааны оршуулга байж болох мэт. Эрэгтэйчүүдийн зогсох хэсгийн доор нэгэн язгууртан эрэгтэйг

ихэмсэг байдалтай, малгайтай (өдгүй, шилэвчит монгол малгай) дүрсэлсэн нь өөд болоочоос хийгээд заншилд оролцогч бусдаасаа дээгүүр зиндааны хүн бололтой. Үүгээрээ Зураг 5а-тай адилсаж байгаа юм. Уг зураг нь урлал, гүйцэтгэлийн хувьд тийм ч нарийн сайн биш тул эд өлөгийн дүрслэлээс харагдах мэдээллийг нилээд ерөнхийд нь тоймлон үзэхээс өөр аргагүй. Авс нь өндөр хөлтөй, их биеийг банзалж бэлтгэсэн модоор хийсэн, авсны таглааг тод ялгарах төмөрлөг зүйлсээр зэрэгцүүлэн их биед бэхэлсэн байна. Сэнтийнд, авсны цаадтай хучлага ба өдөт малгай зэргийг өлгөсөн болов уу гэмээр байна. Энэ зурагт эмэгтэйчүүдийн толгойд ямар нэг малгай мэт зүйл үзэгдэх нь “богтаг малгайнхаа оройг салгаж бэлэвсэрч байв” (Эрдэнэбат, 2006: 119) гэсний жишээ бололтой. Эрчүүд нь малгайн өдөн чимэглэлийг авах, эмэгтэйчүүд нь богтаг малгайн оройг салгах зэрэг нь гоёл зүүсгэл, эрх ямбаны хэрэгслээ түр түдэж (ерөөс гоёж гоодохгүй), ид бах, сүр хүчээ даруусган туйлаас гашуудсаныг харуулах ба талийгаачийг хүндэтгэн дээдэлж цээр барьж буйг илэрхийлж буй хэрэг юм. Харин үүний эсрэгээр талийгаачийг машид гоёж, элдэв зан үйлийн засал хийж гашуудалд бэлтгэдэг байжээ. Зургийн төв доод хэсэгт (Зураг 1, Зураг 2-той адилаар) үнэрт ургамал юм уу, эсхүл утаа гарах уугих мэт дүрслэл нилээд тод зурагджээ. Дундад эртний монголчууд оршуулга, тахилгад анхилам үнэрт арж хүжисийг хэрэглэдэг байсан байж болох тухай зарим сурвалжийн мэдээ цухас өгүүлдэг. Жишээлбэл, Чингис хааны гуч хүү Гамал Бурхан Халдунд бөөгийн мөргөлийн сүм бариулж “... тогтмол анхилам үнэртэй хүж арц шатаан уугиулан, сан тавьж байдаг болгосон ажээ” (Рашид Ад-Дин, 2002: 234) гэсэн байдаг.

Оршуулгын тухай өгүүлсэн энэхүү зургийн зохиомж, хэллэгийн онцлог байдал ба мөн Парист Рашид-Ад-Диний “Судрын чуулган”-аас цуглуулсан эхүүдтэй хамт байгаа зэрэг нь уг судрын эх, түүний зарим хуулбар эхийн гар зургаас (тэр дундаа эхэн үеийн) гарвалтай гэдгийг илэрхийлж байна.

Дашрамд хэлэхэд, Рашид-Ад-Диний “Судрын чуулган”-ы унаган эх нь Перс хэл дээр анх бүтээгдсэн ба дараа нь араб болон бусад хэл рүү орчуулан, мөн хуулбарлан олшруулах хэлбэрээр түгээгдсэн нь нэгэнт тодорхой болсон билээ. Үүнээс ухан үзэхүл, нилээд болхидуу дүрслэл бүхий, хавтгай зургийн (нэг адил хуучивтар) аястай, арга барил ижил, цөөн өнгөтэй зургууд нь перс хэлний анхны (унаган) эхийн чимэглэл зургууд байх магадлалтай. Үүнд, ажиглалтад хамрагдсан зургуудаас Зураг 1, Зураг 5, Зураг 6 нь анхны перс эх болон эхэн үеийн хуулбаруудтай харьцангуй ойр холбоотой, хэмжээний хувьд жижгэвтэр байх (хадгалагдан үлдсэн зургуудын түүхэн он цагтай дүйж байгаа) гэж таамаглахаар байна. Харин нилээд уран чамин олон өнгө үзүүлж, урлал нарийссан барил бүхий бүтээцтэй, арай томхон хэмжээ бүхий үзүүлэн (чимэглэл) зургууд нь хожмын өсөлт хөгжил, туршлагыг илэрхийлжээ гэж үзэж болмоор санагдана.

Нанхиадын эх сурвалж Цао Му Цзы-д өгүүлэхдээ “Монголчууд өөрсдийн наснаас нөхцсөн хаадыг оршуулахдаа, хүний чинээ хоёр хэсэг үнэрт модыг ухаж, авс үйлдэн түүний дотор хүүрийг үстэй дээл, малгай өмсүүлж, цагаан өнгийн илгээр хийсэн гутал, оймс, бүсийг хэрэглэн агуулна. Түүний хамт авсны дотор домбо, ваар, пяр таваг, цом, халбага, савх зэрэг алтан сав суулгыг тавьсны хойно авсыг битүүлж,

дөрвөн алтан цагиргаар бүсэлдэг буй. Хүүр зөөх сүйхийг цагаан эсгий, хивс, хоргойгоор бүтээнэ. ...Авсны өмнөдөд шинэ хувцас өмссөн удган морь унаж, хоргой мэт эдээр жолоо хийсэн, алтаар чимсэн эмээлтэй морь хөтлөн явна...” (Амар, 1989: 163), (Нацагдорж, 1991: 166-170) гэжээ. Мөн “Хэн хүн үхэхэд ихэд гашуудан уйлцгаана. Тийнхүү уйлснаар тэр жилдээ гай дөтгөрөөс хэлтэрнэ гэж үздэг ажээ” (Гильом Де Рубрук, 1988: 116). Бас “... хааны алтан авсын өмнө сөгдөж, ах дүү нар хүзүү тэврэлцэн уйлсаар харангадан эргүүтэж дөрвөн дүү чин ван, дөрвөн тайзци чин вангийн гаслалцах нь маш эмгэнэлтэй, өдөр бүр залгалдахуйяа ...” (Инжинаш, 2005: 378) хэмээн гашуудлыг дүрсэлжээ. Уг сурвалжуудын энэ мэт мэдээ олон талаар перс чимэглэл зургийн дүрслэлтэй давхцаж байна. Мөн “... ерөөс авсыг цагиргаар бүслэх нь зөвхөн хаан ургийнхны оршуулгад хэрэглэдэг өвөрмөц заншил гэдгийг судлаачид нэгэнт тогтоожээ” (Баяр, 1999: 23) гэсэн нь хаад язгууртны оршуулга гэж үзэж байгаа эдгээр зургуудад “... авсыг цагиргаар бүслэх” уламжлал илэрхий тусаж харагдахгүй байгаа ба нөгөөтэйгүүр эдгээр зураг нь булшлах (хөдөөлүүлэх), онголохын өмнөх зан үйлийг илтгэж байгаа тул “цагиргаар бүслэ”-эгүй байж болох юм. Язгууртны онгоныг газарт оршоохдоо буюу булшлахдаа авсны тагийг хааж, цагиргаар бэхлэн оршуулдаг тул энд (оршуулахын өмнөх зан үйлд) дүрслэн харуулаагүй биз ээ.

Ажиглан судалсан зургууд нь бүгд Рашид-Ад-Диний “Судрын чуулган”-тай шууд холбоотой зурагдсан буюу дам холбоо, уламж авсан байж болохоор байна. Он цаг дарааллын хувьд а) Зураг 1, б) Зураг 6, Зураг 5, в) Зураг 2, г) Зураг 3 ба “Исфандиерийн оршуулга”, д) Зураг 4 ба Энэтхэг зураг гэх мэт дарааллаар байж болохоор ба 1310-1330-аад онуудад, Зураг 4 ба Энэтхэг зураг (XVII зуун)-аас бусад зургууд бүтээгдсэн бололтой.

Зан үйлийн дарааллын хувьд а) Зураг 2, Зураг 5, б) “Исфандиерийн оршуулга” (Зураг 4) ба Энэтхэг зураг (Зураг 3), в) Зураг 6, Зураг 1 мэтээр байж болох санагдана. Эдгээр зурагт харуулсан гашуудал (уй хийх) ба салах ёсны үйлдлийн дараа булшлах (хөдөөлүүлэх), онголох (бунхлах), хойлголох, гашуу тайлах зан үйлүүд хийгддэг гэж ойлгож болно.

* * * *

Чингис хааны бунхны талаар маш сонирхолтой аман мэдээ бас байна. Аман мэдээ нь академич Ц.Дамдинсүрэнгийн тэмдэглэлийн тухай дам мэдээ ажээ. 1930-аад оны сүүлчээр Хэнтий нутгаас Их хааны шарилыг хамгаалж үлдсэн сүүлчийн Урянхан хүн гэх хүнд өвчтэй ядуувтар настан тэр үеийн удирдагч Х.Чойбалсантай уулзахаар зорин ирээд уулзаж чадалгүй буцсан гэдэг. Тэрхүү бие муутай хөгшин, Чингис хааны онгоныг хамгаалж ирсэн удмын сүүлчийн хүн гэдгээ хэлж, Онгоны “түлхүүр”-ийг хэнд үлдээхээ мэдэхгүй цөхөрч яваагаа ярьжээ. Үүнийгээ улсын удирдагч Х.Чойбалсанд танилцуулахаар ирснээ хэлсэн байдаг. Ингээд Ц.Дамдинсүрэн гуайтай уулзаад буцсан бололтой. Түүний ярианд Чингис хааны онгоны талаар сонирхолтой мэдээлүүд агуулагдсан байжээ. Тэрбээр Их хааны онгон (бунхан) гурван өөр янзтай байх бөгөөд нэг бунхан нь алт эрдэнэсээр бүтээсэн эд зүйлсийг агуулах аж. Тэнд таван хошуу малын биеийн хэмжээгээр бүтээсэн алтан баримлууд байх бөгөөд нүд, туурай тэргүүтнийг эрдэнийн чулуу сэлтээр бүтээсэн байдаг тухай ярьжээ. Академич

Ц.Дамдинсүрэн гуай энэ тухай тэмдэглэн үлдээсэн нь үгүй. Харин нэрт эрдэмтний тэмдэглэлийг үзсэн итгэлт нэгэн сэхээтэн хуучлан ярьснаас дам ийн нууцхан мэдээлэгдэж үлдсэнийг Зэлмэ овогт О.Бүрэнжаргал (69 настай, 2009) гуай үүнийг бичигч надад сонирхуулсан билээ. Мөн Хэнтий нутгийн нэгэн өвгөн хууч яриаг саяхан сонинд мэдээлэхдээ “үнэрт цагаан занданг хөндийлөн ухааж Их хааны шарилийг хийгээд алтан бүсээр бүсэлж оршуулсан” тухай домгийг нийтлүүлжээ. Эдгээр хууч яриа бол Их хааны бунхны талаар олон домгийн нэг хэсэг юм. Мөн Их хааны хамт хойлгын зан үйлд 40 залуу бүсгүйг морьдын хамт булишилсан гэх эртний домгоос үндэслэн газар доорх Онгоны хэмжээ дамжааг тооцолсон мэдээ ч бий. Чингис хааны онгоныг хайсан АНУ-ын “Чингис хаан” экспедицийн санаачлагч М. Кравиц “хааны онгонд багаар бодоход дөрвөн тонн алт бий” гэж ярилцлага өгөхдөө мэдэгдэж байжээ. 100 гаруй жилийн өмнө Английн судлаач, аялагч Ч.В.Кэмпбелл зүүн монголоор аялахдаа Их хүрэннээс лам, орос газарчинтай явж Бурхан Халдун уулын оройд гараад “...оргилд хүн бүтээсэн нь эргэлзээгүй ... зууван бунхан ... магадгүй Монголд хамгийн том нь ... Чингис хааны оршуулга гэдэгт бид итгэлтэй байлаа ...” гэх зэрэг ноцтой, нарийн тэмдэглэл үйлдэн (Campbell, 1903: 486-518) сэтгүүлд хэвлүүлжээ. Их хааны шарилыг тээж ирсэн тэрэгтэй нь хамт (салахгүй байсан учраас) Бурхан Халдуны оргилд гаргаж оршуулсан гэх домог мэдээг судлаач Михаэль Правдин “Чингис хаан ба түүний өв” (2005) номондоо тэмдэглэсэн бол Судлаач И. де Рахевилз “Миний бодлоор, хааныг онголсон газар нь Гамалын сүмээс (Дунд овоо. Зохиогч) уулын оргилыг хучсан овоо хоёрын хоорондох энгэрт байж болно” (Rachewiltz, 2002). Мөн 1840 оны үест Монголын хожмын удирдагчдын нэг, зөнч V богд Жавзандамба Лувсанчүлтэмжигмэд зохиосон гэх “Хаадыг уг эх ертөнц тогтоож шаахин төр үүссэн зэргийн түүх намтар оршив” хэмээх нууц сударт өгүүлэхдээ “Богд (Чингис хаан. Зохиогч) хорин хоёр он суугаад жаран долоон наснаа шарагчин гахай жилд Сударсун балгаснаа заларч харив. Алтан шарилыг нь Хэнтий ханы оройд залжээ. Эдүгээ Хэнтийн оройд ямар их Богд нар ч заларч болдоггүй амуй. Дарнат богд ар, дунд бэлд нь хүрч овоо босгожээ” (Цэрэнсодном, 2007) гэсэн байна. Уулын хяр өндөр, оргил орчимд монгол язгууртаныг ихэвчлэн бунхлан оршуулж ирсэн уламжлал сүүлийн үеийн судалгааны явцад улам тодорч байгаа ба энэ нь өдгөө болтол удаан хугацаанд үгүйсгэгдэж ирсэнийг хэлэх хэрэгтэй. Алтай нурууны Шарилийн нуруу, Чандмань уул, Их Богд, Хангай нурууны Хантай, Шарилийн магнай, Тарвагатай, Ноён уулс, Хэнтийн Их нурууны зарим сарьдагуудад оршин буй монгол язгууртаны (алтан ургийн) оршуулгын (ихэсийн) газруудыг хүний болон байгалийн хүчин зүйлээс хамгаалж, улмаар танин мэдэх шаардлага тулгамдаж байна.

Бурханы Халдуны оргилийн мөнх цэвдэгт Чингис хааны алтан авс оршин буй гэх таамаг, сурвалж мэдээлэл зөвхөн үүгээр зогсохгүй сүүлийн үед уламаа нэмж олдсоор байгаа нь бидэнд ер бусын цаг дөхсөнийг гэрчлэх бус уу.

Мөн XIX зуунаас Чингис хааны онгоны талаар түүх домгийн нууц мэдээлүүд ил гарч, судлан сонирхох явдал эрс нэмэгдэж, нэг ёсондоо гадна дотны анхааралыг хурцаар татах болсон гэнэтийн гэмээр шалтгаан нөхцөлийг бид анзаарч шинжлэн үнэлэлт дүгнэлт өгөх шаардлагатай болжээ.

ДҮГНЭЛТ

Салах ёс ба Гашуудлын зан үйл. Энд ажиглалт хийсэн эртний зургууд нь бидэнд Монголын хаад угсаатнуудын шарилыг авсанд хийж зан үйл үйлдэх (гашуудах, уй хийх, салах ёс гүйцэтгэх) зурвас хэсгийн үйл явдалыг “кино мэт” үзүүлж, олон шинэ мэдээлэл өгч байна гэж ойлговол зохилтой. Эдгээр зургууд нь Рашид-Ад-Диний “Судрын чуулган”-д анх дүрслэгдсэн буюу олонх нь уг судраас шууд болон дам уламжлан үлджээ. Ижил сэдэв бүхий эдгээр чимэглэл ба үзүүлэн таниулах зургуудын өөр хоорондын ялгаатай арга барил, уран чадвар, дүрслэлийн

онцлог, тусган харуулсан зан үйл, соёл, эд өлөгийн зүйлсээр баримжаалан тэдгээрийн зурагдсан он дарааллыг (эх сурвалжийн харьцуулсан ажиглалт судалгаа хийж) тоймлон тогтоож болохоор байна. Гэхдээ эдгээр зургуудын уугуул эх болон дэлхийн янз бүрийн өв сангуудад хадгалагдсан байж болох бусад эхүүдийг эрэн олж, гардаж нягтлан судлах, шинжлэн харьцуулалт хийхээс энэхүү түүвэр ажиглалт нь илүү ач холбогдолтой байж чадахгүйг хүлээн зөвшөөрөх учиртай.

Эртний оршуулах, гашуудах (салах ёс) зан үйлийн эдгээр зургууд нь адил өгүүлэмж, төстэй зохиомжоороо нэг нэгнээ нөхөн баталж, үйл явдлын болцыг тод хэлж өгч байгаагаараа олзуурхам, чухал ач холбогдолтой юм.

Хаан, удирдагч хүнийг өөд болоход оршуулгад зориулан тансаг эрхэм авс бэлтгэнэ. Оршуулгад авс, тэр дундаа гоёмсог авс хэрэглэх нь нүүдэлчдийн хувьд жирийн бус (язгууртан, эрхэмлэх хүний) оршуулгын хэлбэр болно. Оршуулахын өмнө уй хийхэд шарилыг авсанд хийж, сэнтий ба хүндэтгэлтэй байранд зална. Оршуулгын ёслолд сэнтийг дүрслэх нь шууд утгаар хаан ба хатан, мөн угсаа залгамжлагчийг дүрсэлж байна гэж үзэж болно. Авсны дээр заримдаа малгай (титэм, дуулга), мөн бэлгэдэл шүтээн эд зүйлс тавина. Гашуудлын салах ёс хийхэд хүндэтгэлтэй байрлуулсан авсны хоёр талд заншлын дагуу эрэгтэй, эмэгтэйгээр ялгаран (баруун талд эрчүүд гэх мэт) зогсож гашуудал үйлдэх (төрийн бусад ёслолд ч ийм байрлал голлоно) ба энэ үед авсанд дагалдуулдах эд өлгийг хийнэ. Гашуудагсад бүгд малгайгаа авч үсээ задлан эмгэнэх ба эмэгтэйчүүд нь (зарим үед) богтаг малгайн оройг авч гашуудал үйлдэнэ. Гашуудалд бараандуу хувцас өмсөцгөөж (гоёл, чимэг зүүсгэлээ мөн тайлж) байжээ. Мөн үнэрт ургамал (эртний Түрэг оршуулгад лийрийн мод хэрэглэдэг байсан гэдэгтэй төс мэт), арц мэтийг оршуулгад хэрэглэнэ. Авсыг мод зэргээр хайрцаг хэлбэртэй үйлдсэн нь зонхилж байсан бололтой. Авс нь уламжлалт элдэв чимэг олонтой байна, мөн алт эрдэнэсээр тоноглох тохиолдол ч байжээ (Чингис хааны алтан хайрцаг (авс) ийм байж болохыг сурвалжуудад цөөнгүй мэдээлдгийн зарим нь энд байгаа зургууд болно). Чингис хааны үнэн цогцсыг оршуулсан гэж үзвэл, Их хааны авс нь үнэт модоор үйлдэж, алтаар бүрсэн буюу чимэглэсэн эрхэмсэг нэгэн бүтээл байх боломжтой. Шарилыг булшлах, онголох газарт залахад тээх морьд, бүрлээчийн унаа зэргээс бусад морь малгүй, авсыг хучиж, оршуулгад оролцогсод явганаар явж хүрдэг байсан бололтой. Энгэрээ ярах, цээжээ даран эмгэнэх (дэлдэх), үсээ задгайлах, мөн үсээ үгтээх (толгойгоо барих), гараа алдлан тэнгэрт гашуудан хандах зэрэг онцлог зан үйл нь дээрх зургуудад нэгэн адилаар давтагдан дүрслэгдсэн ба Монголын Алтан ордны нөлөөнд олон арван жил (200 жил) байсан зарим угсаатнуудад мөн эдгээртэй төстэй гашуудал, бухимдлын зан үйл байдаг нь сонирхууштай юм.

Үсээ задгайлах, сэгсгэр урт үстэй явахыг эдүгээ болтол зарим настан монголчууд цээрлэн дургүйцэж байдаг нь уламжлалын үүднээс “муу ёр”, үхээр, сүнстэй холбоотой үйлдэл гэж үздэгээс тэр билээ. Бөө тамлагын зан үйл нь үхэгсэд ба тэдний сүнстэй холбогддог тул үсийг аль болох сэгсийлгэн, мөн тодотгон (нэмэлтээр) хялгас үсэн унжлага бүхий сагсгар малгай өмсгөлийг хэрэглэнэ. XX зууны дунд үе хүртэл монголчууд уй гашуу, зовлонгийн илэрхийлэл болсон урт задгай үс тавихыг жирийн амьдралдаа цээрлэсээр байжээ.

Уй гашуу үйлдэх үеэр мөн эртний нүүдэлчдийн “гэгэх” ёс ба харуусан шүлэглэх, уйлан ухилан дуудах, ерөөл өргөх, мөн бөө тамлага үйлдэх зан үйл монголчуудад байсан гэж үзэж болохоор байна.

Эдгээр зан үйлийг гүйцэтгээд дараа нь монголчууд язгууртаныг олон хэлбэрийн (уул өндөрлөг газарт, оргилд гэх мэтээр. Зохиогч) оршуулга /булшлах, хөдөөлүүлэх. Зохиогч/ үйлдэж ирсэн ба бунхлах соёлыг ч бас янз бүрийн хэлбэрээр эртнээс өнөө болтол баримталж ирсэн нь бас бий (“Монгол бунхнууд” Хавсралт 1 зургууд үз).

Илхаадын буюу Ойрх дорнод, Дундад Азийг захирч байсан монголчуудын язгууртны оршуулгын зан үйлийн талаар ийнхүү тухайн бүс нутгийн соёлын нөлөө бүхий зураг-дурсгалууд үлдсэн бол Монголын эзэнт гүрний бусад бүс нутаг буюу Хятад (Юань улс), Дундад Ази (Цагаадайн улс), Орос (Алтан ордны улс), Монгол (Төв Монгол)-ыг захирч байсан монголчуудын язгууртны оршуулгын зан үйлийн талаар энд жишээ авсан зургуудтай дүйхүйц нүдэнд харагдах дурсгал одоогоор Өвөрмонголын Ордос дахь Аржайн агуйн дурсгалыг эс тооцвол ховор байна. Мөн монгол язгууртны оршуулгын талаар Перс арга барил бүхий бусад сонирхолтой зургуудын олдвор (энд ажиглалт хийснээс гадна) олдож болох ба тэдгээр нь зарим дүрслэл, зурагдсан цаг хугацааны хувьд өөр өөр байж болох ч зан үйлийн хувьд (алтлаг тоногтой авс, дээр нь бэлгэдэл зүйлс байрлуулах, авсны хучлага, үсээ задлан гашуудах, харууслын ааш аяг, шарилд хандан үг хэлэх мэт) энд хийсэн судалгааны мэдээлэлтэй ерөнхийдөө тохирч байдаг (Хавсралт 2. Нэмэлт зургууд үз). Ер нь Төв Азийн нүүдэлчдийн оршуулгад зураг дүрслэл, уран чимэглэлийн ул мөр олдох нь Скиф, Хүннүгийн үеэс нааших олдворуудад олонтоо тааралддаг ажээ.

Түүхэн гар зураг. Өөр хоорондоо эх сурвалж болон зан үйлийн дүрслэлийн хувьд уялдаатай эдгээр (монгол оршуулгын сэдэвтэй) гар зургууд эртний нэгэн онцлог үйл явдлыг тодорхой өгүүлж байгаа хийгээд мөнхүү дүрслэлүүд (гар зургууд) нь түүхэн сурвалжуудыг үзэгдэх харагдах (визуальный ба visual) хэлбэрээр адил төстэй агуулгаар бататгаж байгаагаараа үнэ цэнэтэй юм.

Перс судрын түүхэн гар зургийн нэршлийг олон улсын судалгаанд овор хэмжээ, бүтээгдсэн арга барил, агуулга, зориулалтаас үндэслэн номын бичил чимэглэл зураг (miniature painting), судрын ба үзүүлэн зураг (illustration, illumination), шүтээн зураг (iconograph) гэх мэтээр янз бүр нэрлэж ирсэний дотор miniature буюу бичил чимэглэлийн урлаг гэх нэршил түгээмэл хэдий ч үнэндээ бол illustration (үзүүлэн таниулах зураг) нэршил нь олонх “олдворууд”-д тохирохоор байна. Перс судрын зургуудад эдгээр нэршилд тохирох аль аль хэлбэр нь байдаг ч Үзүүлэн зураг, номын зураг, тайлбар зураг (illustration, иллюстраци, illumination) гэх голлох нэршил сүүлийн үед англи, герман хэлт судалгаанд зонхилох болсон нь судраас уламжит зургуудын үндсэн шинж чанарт нийцэж байна. Харин монгол хэлт судалгаанд Персийн түүхэн гар зургуудыг миниатюр (номын чимэглэл зураг. miniature) буюу бичил чимэглэл гэх агуулгаар нэрлэх нь хэвшиж буйг хянаж, улмаар нэршлийг нэг мөр болгож тодрууштай мэт. Перс гар бичмэл судрын зургууд нь анхны үедээ танин мэдүүлэх агуулгыг чимэглэл хэлбэртэйгээр,

жижгэвтэр хэмжээтэйгээр илэрхийлэх байдлаар бүтээгдэж байжээ гэмээр, харин хожмын хуулбар судруудад үзүүлэн таниулах зорилго, агуулга нь шууд давамгайлж, томхон хэлбэр хэмжээтэйгээр зурагдах болсон төдийгүй судрын хуудсуудыг бүхэлд нь дамнасан дэлгэц (panoramic) зураг ч бий болсон байдаг. Эртний сурвалжид үзүүлэн (чимэглэхээс гадна таниулах, сонирхуулах) зураг хэлбэрээр бүтээгдсэн гар зургийн өвүүд нь зөвхөн оршуулга төдийгүй түүхэн үйл явдлыг бусад олон сэдэв, олон агуулгаар бодтой илэрхийлэн үлдээхийн тухайд тэр үедээ хамгийн дэвшилтэд арга хэлбэр болж байжээ. Тиймээс хожмоо энэ арга уламжилж Монголын эзэнт гүрэн даяар төдийгүй Их Могол, Иран, Оттоман гүрэн, Европод онцгой хэрэг явдалыг таниулан дүрслэх (illustration) энэ аргыг өргөн дэлгэр хэрэглэж, түүхэн бичлэгийг баримтжуулах нэгэн чухал хэрэгсэл болгож байжээ. Харин шашин, домог үлгэрийн судруудад хээ чимэг, шүтээнчлэл, домогчлон гоёчлох (дээдлэх хэлбэрээр) дүрслэлүүд голлон уламжилж, бичил чимэглэл (miniature art) үйлдэх нь давамгайл байжээ. Түүхийн ухааны доктор Д. Баяр, У. Эрдэнэбат нарын дундад эртний Монголын түүхтэй холбоо бүхий зарим гар зургуудыг судалсан бүтээлүүд (Баяр, 1990: 87-98; Баяр, Эрдэнэбат, 2004: 208-231; Эрдэнэбат, 2006.) нь чимэглэл (үзүүлэн) зургийн талаар хийсэн Монгол судлаачдын чухал алхам, тэдгээрийн үнэ цэнийг тодорхойлохыг хичээсэн анхдагч үр дүн болж байна. Перс иллюстрацид (үзүүлэн зурагт) ажиглалт хийх явцдаа дээр дурдсан эрдэмтэд (дурдсан бүтээлүүдэд) мөн монгол язгууртны оршуулгыг дүрсэлсэн зарим зурагт тодорхой хэмжээгээр үнэлэлт өгсөн байдаг. Цаашид, Монголын эзэнт гүрний түүхтэй холбоотойгоор (тухайн цагт бүтээгдэж) дэлхийд тархсан олон арван гар зургийг (жишээлбэл, Перс иллюстраци болон бусад зургууд, Юань улсын хөргүүд болон бусад, Европ (Парис Мэтью гэх мэт) зургууд, мөн бусад бүс нутагт мөнхүү сэдвээр тархаж үлдсэн зургууд гэх мэт) болж өгвөл бүхэлд нь хамарсан иж бүрдэл судалгаа явуулж, өмнөх ажиглалтыг гүнзгийрүүлэн шинжлэх ухааны үнэ цэнийг тодорхойлсон дорвитой ажил хийх шаардлага монголын судлаачдад гарч байна.

Перс эх сурвалжуудад үзүүлэн зураг бүтээх нь түүх бичигчдийн хувьд, зураачдын хувьд Эзэнт улсын өмнө хариуцлага хүлээсэн явдал байлаа. Тиймээс бодот байдлыг харуулан баримтжуулах түүхэн итгэмжит зарлага байж, дүр төрхийг жинхэнэ үнэнээр үлдээх эрмэлзлийг хамгийн ихээр агуулж, түүнээ хичээн гүйцэлдүүлж байсны ул мөр нь энэхүү монголын сэдэвтэй Перс миниатюрууд (иллюстрациуд) юм. Тийн бүтээгдсэн “ажил”-ууд нь соёлын солилцооны түүхийг илэрхийлэх үнэ цэнэтэй төдийгүй түүхэн үйл явдлыг баримтжуулах чухал шилдэг хэрэгсэл гэдгээ нотлон үлджээ. Мөн дүрслэх урлаг, соёлын үнэтэй дурсгал болохыг ч хэлэх ёстой. Гар зураг бол тухайн цагтаа өнөөгийн гэрэл зураг, телевиз, интэрнэт мэт мэдээллийн технологийн шилдэг хэрэгслийг орлох visual арга болж байсан гэдэг нь дамжиггүй. Эртний даяар гүрнийг байгуулан удирдсан монголчууд ийнхүү мэдээллийн үнэ цэнийг хэрхэн эрхэмлэдэг байснаа түүхэнд илтгэж, Еврази дахь уран зураачдыг өөрсдийн зорилгод татаж түүх, урлалын олон баримтыг үлдээснээрээ соёл түгээгч-тээгч угсаатан гэдгээ баталжээ. Нүүдэлчин Монголчууд

нь байлдан дагуулсан суурин иргэншлийнхээ соёлын нөлөөнд өөрсдөө дагаж уусах явдал байсан хэдий ч тэдгээр соёлыг хөгжлийн шинэ түлхэлтэд хүргэх түүхэн үүрэг гүйцэтгэсэн юм.

НОМ ЗҮЙ

- Амар А. 1989. Монголын товч түүх. УБ
- Батсайхан З., Даваа Н., Бор Ж., 2009. Тэнгэрийн овоо Их хааны бунхан мөн үү. Бурхан Халдун уулнаа Буурал түүхийн жимээр. УБ. х. 13-26
- Баяр Д., 1990. Перс номын чимэглэл зурагт хадгалагдан үлдсэн монгол уран зургийн зарим мэдээ. Түүхийн судлал. Боть 24. УБ., х. 87-98
- Баяр Д., 1999. Алтан ургийн язгууртны нэгэн булшийг судалсан нь. УБ
- Баяр Д., Эрдэнэбат У., 2004. Дундад зууны монголчууд бунхны ханын зурагт. Археологийн судлал. Боть 22. УБ., х. 208-231
- Груссе Р., 2004. Чингис хааныхны Монголчууд. УБ., х. 51
- Инжинаш, 2005. Хөх судар. УБ., х. 375-379
- Лувсанданзан, 1990. Алтан товч. УБ.
- Марко Поло, 1987. Орчлонгийн элдэв сонин. УБ
- Монголын нууц товчоо (сонгомол эх) 2005. УБ
- Мырзатай Ж., Каржаубай С., 2006. Атлас Орхонских памятников. УБ
- Мэнэс Г., 2008. Чингис хааны тэнгэрт гарсан сар өдрийг Григорийн он тооллын ёсонд шилжүүлэн тогтоохуй. “Монголын Нууц Товчоон”-ыг нээсэн нь. УБ.
- Нацагдорж Ш., 1991. Чингис хааны цадиг. УБ
- Плано Карпини Жиованни Дель, 1988. Монголчуудын түүх. УБ
- Пэрлээ Х., 1956. Эртний монголчуудын үхэгсдээ оршуулж байсан зан үйлийн асуудалд. УБ
- Рашид-Ад Дин, 2002. Судрын чуулган. УБ.
- Рубрук Гильом Де, 1988. Дорно этгээдэд зорчсон минь. УБ.
- Саган цэцэн, Эрдэнийн товч, 1662.
- Саундерс Ж.Ж., 1992. Монголын байлдан дагуулал. УБ
- Цэрэнсодном Д., 2007. Монголын бурхны шашны уран зохиол-II.
- Эзэн богд Чингис хааны домог оршвой, 1992. Эмх. Х. Сампилдэндэв, УБ. х. 57
- Эрдэнэбат У., 2006. Монгол эхнэрийн богтаг малгай. УБ
- Blair, Sheila S., 1995. Compendium of Chronicles: Rashid-Ad-Din's Illustrated History of the World. New York
- Campbell C.W., 1903. Journeys in Mongolia. The Geographical Journal, Vol.22, No.5 (Nov., 1903), pp.485-518
- Darnley E., 2002. Mongol Costume in Art.
- Dschingis khan und Seine Erben. 2005. Bonn. Deutschland
- Juvaini Ata-Malik. 1997. Genghis khan: The history of the world-conqueror. Manchester
- Man J., 2005. Genghis khan: life, death and resurrection. London
- Rachewiltz, Igor de, 2002. Where is Genghis Khan buried? Myths, Decertions and Reality. unpublished paper.
- Roux J.P., 2002. Gengis khan et L'Empire mongol. London
- Roux J.P., 2003. “Funeral of Genghis khan”. Genghis khan and The Mongol Empire. p. 32
- Stefano C., Adamjee Q., 2003. "Folios from the Jami' al-tavarikh (Compendium of Chronicles)"
- Tumbull, 2003. Mongol Warrior 1200-1350.
- Weatherford J., 2004. Genghis khan and Making of the Modern World. New York
- Websites**
- Dar Anahita: “Rashid's Persian Patterns” (Salwar by Charles Mellor)
http://afe.easia.columbia.edu/mongols/figures/figu_ogo.htm
- The Indo-Mongolian Society of New York: “Mongolian History-Online Resources”
<http://www.mongolianculture.com/>

Los Angeles County Museum of Art: "The Legacy of Genghis Khan: Courtly Art and Culture in Western Asia, 1256-1353"

http://www.lacma.org/khan/index_flash.htm

The Metropolitan Museum of Art: "The Legacy of Genghis Khan: Courtly Art and Culture in Western Asia, 1256-1353" November 5, 2002-February 16, 2003

http://www.metmuseum.org/special/se_event.asp? OccurrenceId={36C74128-EEF8-11D5-

http://www.metmuseum.org/toah/hd/khan8/hd_khan8.htm (October 2003) Mongols"

<http://depts.washington.edu/uwch/silkroad/exhibit/mongols/mongols.html>

"Coffin of Genghis khan". Web. Columbia University: "The Mongols in World History"

SUMMARY

G.Badamsambuu


SOME MEDIEVAL INFORMATION OF ILLUSTRATIONS ON HIDDEN FUNERALS OF MONGOL KINGS

(The Painting Heritages described the coffin of Chinggis khaan)


One of the historical mystic rites described in Persian illustrations about the medieval Mongolian Empire is concerned with the funeral of Chinggis Khaan. Some illustrations, that describe either directly or indirectly the burying of the Great Khaan and the funerals of Mongolian aristocrats, have been linked with the Compendium of Chronicles, which is an illustrated manuscript by Rashid-Ad-Din, a court vizier and historian. Most of the studied ancient illustrations have already been published in various studies as linked with the funeral of Chinggis Khaan, and even though they are all different from one another they carry common descriptions about the funeral rites of medieval Mongolian aristocrats. This observation is conclusive in determining that the Persian Illustrations, or miniatures, that describe the funerals of Mongolian tribe leaders and aristocrats can indeed be considered as visual transcriptions of real events taking place during the ancient and secret Khaans' funerals, all of which still remain hidden to this day. Following this observation, the type of ethnographic rituals described in the ancient free-hand sketches prove the veracity of historical sources, namely the authenticity of the texts concerned with the funerals of medieval Mongolians aristocrats, and enriches them with new information. This observation hence directly contributes to the studies of Chinggis Khaan and other kings, and to the studies concerned with recognising the ancient secret rituals of Mongolian aristocrats.

ХАВСРАЛТ 1.


МОНГОЛ БУНХНУУД



Чингис хааны ууган хүү Зүчийн бунхан (Казакстан)




ИЛ ХААД (Монголын) бунханы үлдэц (Дундад Ази)



Ил хаадын удамыг оршуулсан чулуун авс

ЧИНГИСИЙН ОНГОН (Ордос. Өвөрмонгол. Хятад)




(2008 он)



(1930-аад он)

МОНГОЛ ХААДЫН ОРШУУЛГЫН ТУХАЙ ДУНДАД ЭРТНИЙ ГАР ЗУРГУУД

ӨЛЗИЙТ ХААНЫ БУНХАН /XIV зуун, Иран/
(Бунханы байгуулалт, дотоод хэсгүүд)






Газан хааны бунхан (Ил хаадын улс). XIV зууны эхэн үеийн гар зураг. Тебриз(!). Иран. Шунх, шороон будаг, цаас. (Хэмжээ 36.2 х 29 см). Герман. Берлиний Улсын номын сан. Пруссын соёлын өв, Дорно дахины тасаг. Diez A y. 70, s.13



Түшээт хан Гомбодоржийн бунхан (Эрдэнэ зуу)



200 жилийн өмнөх хошуу ноёны бунхан
(Говь-Алтай, Монгол)



ХАВСРАЛТ 2.

Нүүдэлчний гашуудал. Рашид-Ад Диний “Судрын чуулган”-ы зураг. Энэ зургийн онцлог нь хээр тал нутагт гэрийн гадаа (үүдэнд) гашуудал үйлдэж байна. Зурагт эрэгтэй, эмэгтэй хүний байрыг сольж дүрсэлсэн бололтой. Авсны дээр араб үсгээр Коран судрын эшлэлээс бичсэн бололтой байна. Гэрийн дээврийн хээ чимгийг монгол уламжлалаар уран, нарийн гоёмсог урласан хирнээ хүнийг дүрслэхдээ төдийлөн гүйцэд чадамгай дүрслээгүй нь XIV зууны эхэнд перс зургийн аливаа ахуйг дүрслэх арга барил, гүйцэтгэлийн онцлогтой холбоотой. Хүмүүсийн төрхийг дүрслэхдээ Зураг 1-д гашуудалд оролцогч хүмүүсийг дүрсэлсэнтэй нэн адил төрхтэй зуржээ.



Ордоны гашуудал. Зургийн гүйцэтгэлийн (уран чадварын) хувьд хожуу үед (XVI-XVII зууны үе байх магадлалтай) хамаарна. Араб, перс маягийн засал бүхий ордонд дээдсийн унтах орон дээр авсыг тавьжээ. “Хаан ор суух” (хаанд өргөмжлөгдөх) гэдэг эртний үг нь унтах ор, суух сэнтийтэй ямар нэг талаар холбоотой эсэхийг нягтлууштай. Учир нь хаан дээдсийг нас барахад шарилыг авсанд хийгээд хойморын сэнтий (ор сэнтий), эсхүл унтах орон дээр тавьсныг дүрсэлж байгааг бид анхааран үзэх шаардлагатай мэт. Гэхдээ алтан чимэглэлтэй авс, авсны хучлага, авсны дээр тавьсан бэлгэдэл зүйл, үсээ задлан гашуудах, энгэрээ ярах, гараа цээжиндээ авах, алдлан өргөх, үсээ үгтээх (толгойгоо барих), хашгирч цурхиран уйлах зэрэг эд өлөг, зан үйлээрээ ажиглалт хийсэн миниатюруудтай адил байна. Мөн авсны дээдтэй суух эрийг бусдаас сүр бараатай, үс ихтэй, мөн ямар нэг зэмсэг барьснаар дүрсэлсэн ба нэгэн гивлүүртэй эмэгтэй хүн авсыг тэврэн ухилах (эсхүл үглэн дуулах) нь тод анхаарал татахаар байна. Энэ нь “гэгэх” (гашуудлын ерөөл) ёстой холбоотой байж магад. Ордоны гашуудалд өөр өөр арьстан ястан оролцож, монгол ёсоор гашуудал илэрхийлж байж болох мэт.



Язгууртны шарил тээх (залах) нь. Гэр тэргийг амрах, аян дайн хийхэд, аялахад ашигладаг байснаас илүү дээдсийн шарилыг тээхэд зориулан гаргаж байсан бололтой гэж зарим судлаачид тэмдэглэжээ. Энэ перс зурагт, олон үндэстний хүмүүс гашуудан гэр тэрэгний цувааг тойрон явцгааж, шүхэрээ хумьж, зарим нь цувааг гашуудан үсээ задлан угтаж, өнгөрөөж байгаагаар дүрсэлжээ гэж үзэхээр байна. Гэр болон гэрийн дээр суусан шонхор шувуу, зарим эрчүүдийн шибэлгэр үс, зарим гашуудагсад малгайгүй, амандаа хаалт хийсэн ба ташуу захтай дээл зэрэг нь монголчууд болохыг илтгэнэ.

